


Үндэсний хөгжлийн газрын даргын
2020 оны 06 сарын 18 өдрийн 11400т
тушаалын хавсралт



**УЛСЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ХӨТӨЛБӨРТ ТУСГАХ ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ,
ЭРЭМБЭЛЭХ, СОНГОХ, ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ АРГАЧЛАЛЫГ
АШИГЛАХ ГАРЫН АВЛАГА**

2020 он

Агуулга

Нэгдүгээр бүлэг. Ухох-т тусгах төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавих үндсэн зарчим, аргачлалын бүтэц, агуулга	2
1.1. Ухох-т тусгах хөрөнгө оруулалтын төслийн санал хүлээн авах, мэдээллийг нягтлан шалгах.....	2
1.2. Ухох-т тусгах хөрөнгө оруулалтын төслийг үнэлэх	4
1.3. Ухох-т тусгах хөрөнгө оруулалтын төслүүдийг эрэмбэлэх, сонгох.....	5
1.4. Ухох-т тусгагдсан төслийн хэрэгжилтийг хянах	6
1.5. Ухох боловсруулах	6
1.6. Ухох-т тусгагдсан төслийн хэрэгжилтийг хянах	7
Хоёрдугаар бүлэг. Ухох-т тусгах хөрөнгө оруулалтын төслийн санал хүлээн авах, мэдээллийг нягтлан шалгах.....	8
Гуравдугаар бүлэг. Ухох-т тусгах төслийг үнэлэх аргачлал.....	16
3.1 Ухох-т тусгах төслийн үнэлгээний үе шат	16
3.2 Төслийн урьдчилсан үнэлгээ.....	17
3.3 Төслийн иж бүрэн үнэлгээ	18
3.4 Ерөнхий шалгуур үзүүлэлт 1: ач холбогдол.....	18
3.5 Ерөнхий шалгуур үзүүлэлт 2: “хэрэгжих боломж”.....	29
Дөрөвдүгээр бүлэг. Ухох-т тусгах төслийг эрэмбэлэх, сонгох аргачлал	39
Тавдугаар бүлэг. Ухох-т туссан төслийн хэрэгжилтийг хянах	41
5.1 Ухох-т тусгагдсан төслийн хэрэгжилтийг хянах	41

УДИРТГАЛ

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр гэдэг нь урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан нарийвчлан төлөвлөсөн дунд хугацааны бодлогын баримт бичиг юм.

Энэхүү дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг "Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль", "Төсвийн тухай хууль", Засгийн газрын 2018 оны 348 дугаар тогтоолоор батлагдсан "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах нийтлэг журам" зэрэгт үндэслэн Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага боловсруулж, Засгийн газар дөрвөн жилд нэг удаа баталж, жил бүр тодотгодог. Уг хөтөлбөрт улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийг урт хугацаанд хангахад чиглэгдсэн, нэгээс дээш жилийн хугацаанд, улсын төсөв, гадаадын зээл, тусламж, төр-хувийн хэвшлийн түншлэл, Монгол Улсын Хөгжлийн банкны санхүүжилтээр хэрэгжих, 30.0 тэрбум төгрөгөөс дээш өртөг бүхий дэд бүтэц, хөгжлийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хамруулна. Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь ТЕЗ-аас ирүүлсэн хөрөнгө оруулалтын төслүүдийг урт, дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан хянан нэгтгэж, холбогдох аргачлалын дагуу хөтөлбөрт тусгах төслийг тэргүүлэх ач холбогдолоор, хэрэгжүүлэх дарааллыг тогтоон сонгон эрэмбэлж, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, түүний тодотголын төслийг боловсруулна. Мөн УХОХ-ийг боловсруулахтай холбоотой аргачлал, заавар, удирдамж, маягтыг боловсруулан баталж, мөрдүүлэхийн төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, Засгийн газрын агентлагийн УХОХ хариуцсан албан хаагчдыг сургах, дадлагажуулах, мэргэшил арга зүйн зөвлөгөө өгөх үндсэн чиг үүрэгтэй.


Энэхүү чиг үүргийнхээ хүрээнд Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон яам, агентлаг, аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газрын УХОХ хариуцсан албан хаагчдад зориулан Үндэсний хөгжлийн газар, Японы олон улсын хамтын ажиллагааны (ЖАЙКА) байгууллагын "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр боловсруулах чадавх бэхжүүлэх төсөл"-ийн багтай хамтран уг хөтөлбөрт тусгах төсөл, арга хэмжээнүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавих аргачлалыг хэрхэн ашиглахыг тайлбарласан гарын авлагыг боловсруулаад байна.

Уг гарын авлага нь үндсэн дөрвөн бүлгээс бүрдэх ба 1 дүгээр бүлэгт УХОХ-т тусгах төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үндсэн зарчим, аргачлалын бүтэц, агуулга, 2 дугаар бүлэгт УХОХ-т тусгах хөрөнгө оруулалтын төслийн санал хүлээн авах, мэдээллийг нягтлан шалгах, 3 дугаар бүлэгт УХОХ-т тусгах төслийн үнэлэх, 4 дүгээр бүлэгт УХОХ-т тусгах төслийг эрэмбэлэх, сонгох, 5 дүгээр бүлэгт УХОХ-т туссан төслийн хэрэгжилтийг хянах талаар дэлгэрэнгүй тайлбарласан болно.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УХОХ-Т ТУСГАХ ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ, ЭРЭМБЭЛЭХ, СОНГОХ, ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ҮНДСЭН ЗАРЧИМ, АРГАЧЛАЛЫН БҮТЭЦ, АГУУЛГА

Төсвийн ерөнхийлөн захирагч нь хөрөнгө оруулалтын төслийн саналаа энэхүү аргачлалын хоёрдугаар хэсэгт заасан шаардлагад нийцүүлэн, "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах хөрөнгө оруулалтын төслийг боловсруулах аргачлал"-ын дагуу боловсруулж, Сайдын/даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн, уг хурлын тэмдэглэл болон салбарын өмнөх оны хүлээгдэж буй гүйцэтгэлийн тайлан, дэлгэрэнгүй танилцуулгын хамт 2 дугаар сарын 15-ны дотор Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь тэдгээр төслүүдийг хүлээн авч, үнэлж эрэмбэлэн УХОХ, түүний тодотголд тусгана.



Зураг 1.1 Хөрөнгө оруулалтын төслийг УХОХ-т тусгах үе шат

1.1. УХОХ-т тусгах хөрөнгө оруулалтын төслийн санал хүлээн авах, мэдээллийг нягтлан шалгах

Төсвийн ерөнхийлөн захирагч УХОХ-т тусгах төслийн саналыг жил бүрийн 2 дугаар сарын 15 ны дотор заагдсан "Төслийн саналын маягт", аргачлалын 3 дугаар бүлэгт заагдсаны дагуу төслийн өөрийн үнэлгээ болон холбогдох бичиг баримт, тухайн жилийн шинээр тусгуулах төслийн үнэлгээний нэгдсэн дүгнэлтийн хамт Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ. Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ТЕЗ-аас ирүүлсэн төслийн санал авах нягтлан шалгах бүхий 2 байгууллага "Төслийн саналын маягт" болон холбогдох бичиг баримтын иж бүрдлийг Хавсралт 1-н шалгана.

Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хариуцсан албан хаагч Төсвийн ерөнхийлөн захирагч болох салбарын яам, тамгын газрын хариуцсан албан хаагчтай нягт холбоотой ажиллан, бичиг баримт бүрдүүлэлт, агуулга болон шинэ төслийн явц, төслийн бэлтгэл ажлын мэдээллийг тодруулна.

"Шинээр тусгах төсөл" нь тухайн төслийн төлөвлөлтийн явцаас шалтгаалан бэлтгэл ажлын нөхцөл өөрчлөгдөх тул санал хүлээн авах үед тухайн саналын маягт, холбогдох бичиг баримт, ажлын явцад тохирсон байдлаар боловсруулагдсан байх шаардлагатай. Төслийн саналыг "Төслийн саналын маягт"-ыг холбогдох аргачлалын дагуу бүрэн бөглөсөн эсэхийг Хавсралт 2-ын дагуу нягтална. Хэрэв төслийн саналад тухайн төслийн төлөвлөлтийн бодит байдалд шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлээгүй буюу Төслийн саналын маягууд дахь хариулсан асуултын тоо нь нийт асуултын 50 хувьд хүрэхгүй байвал үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээлэл "хангалтгүй" гэж үзэн үнэлгээ хийхээс татгалзаж энэ тухай эргэн мэдэгдэх эсхүл нэмэлтээр ирүүлэхийг хүсэж, нөхөн бүрдүүлэлт хийнэ.

Төслийн саналын маягууд дахь мэдээллүүдийг асуулт нэг бүрээр нягтлан, ирүүлсэн мэдээлэл нь утга, найруулга, үг хэллэгийн хувьд тухайн төслийн талаар хангалттай мэдээлэл өгөхүйц байгаа эсэх, асуултын утгыг зөв ойлгон бүрэн хариулсан эсэх, хариултауд нь мэдээллийн зөрүүтэй байгаа эсэхийг Хавсралт 2-ын дагуу тодорхойлно.

УХОХ-т тусгах төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавих аргачлалын 3.1.3-д заасны дагуу нягталж үзэхэд шаардлага хангаж буй мэдээлэл нь нийт ирүүлсэн мэдээллийн 50 хувьд хүрэхгүй бол уг төслийг үнэлэхээс татгалзаж энэ тухай эргэн

мэдэгдэх эсхүл шаардлагатай тохиолдолд санал ирүүлэгчээс нэмэлт тодруулга авах, зөрүүтэй болон ойлгомжгүй мэдээллийг засуулах зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ.

Эдгээр бичиг баримтын бүрдүүлэлт буюу төслийн боловсруулалт, төлөвлөлтийн шатны үнэлгээнд зайлшгүй шаардлагатай бөгөөд төслийн үнэлгээ хийгдэх хүртэл бүрдүүлэлт хийж амжаагүй тохиолдолд саналыг хүлээн авах боломжгүй болно. Төсөл боловсруулах бэлтгэл ажлын байдал, санхүүжилтийн эх үүсвэр тус бүр дээр анхаарвал зохих асуудлыг доорх хүснэгтэд нэгтгэн харуулав.

Хүснэгт 1

Шинэ төсөл боловсруулах шат	Санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдсэн эсэх	Санал хүлээн авахад анхаарах асуудал
Бодлогын бичиг баримтад УХОХ хэрэгжих хугацаанд багтан хэрэгжих төсөл хэмээн тусгагдсан хэдий ч ТЭЗҮ, ТЭЗҮС хийгдээгүй.	Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойлогдоогүй.	Зарчмын хувьд тухайн жилийн УХОХ-т тусгахгүй. УХОХ-ийн хэрэгжилтийн 2 дахь жилээс эхлэн хэдэн оноос эхлэхийг сайтар нягтлан, дараа дараагийн жилд оруулахыг санал болгоно.
	Санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүй	
ТЭЗҮС хийгдсэн, төслийн агуулга батлагдсан хэдий ч ТЭЗҮ хийгдээгүй.	Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойлогдоогүй.	ТЭЗҮ хийгдсэн он сарыг сайтар нягталж хүлээн авна. Санхүүжилтийн эх үүсвэр болон санхүүжилт шийдэх гэрээ, хэлэлцээрийн явц үнэлгээний чухал шалгуур болно.
	Санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүй.	
	Санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүй.	
ТЭЗҮ хийгдсэн хэдий ч нарийвчилсан зураг төсөл бэлтгэл шатандаа байгаа.	Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойлогдоогүй.	ТЭЗҮ болон холбогдох бичиг баримтыг нягталж хүлээн авна. Санхүүжилтийн эх үүсвэр болон санхүүжилт шийдэх гэрээ хэлэлцээрийн явц үнэлгээний чухал шалгуур болно.
	Санхүүжилтийн эх үүсвэрээ тодорхойлсон ч эх үүсвэр шийдэгдээгүй.	
	Санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдсэн, хэзээнээс гүйцэтгэл хийх нь тодорхой болсон	
ТЭЗҮ хийгдсэн, нарийвчилсан зураг төсөл зэрэг төслийн бэлтгэл ажлууд хийгдсэн.	Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойлогдоогүй.	Бүх бичиг баримтыг шалгасны үндсэн дээр хүлээн авна. Санхүүжилтийн эх үүсвэр болон санхүүжилт шийдэх гэрээ, хэлэлцээрийн явц үнэлгээний чухал шалгуур болно.
	Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойлогдсон ч, шийдвэрлэгдээгүй.	
	Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдэн, хэзээнээс гүйцэтгэл гаргах нь тодорхой болсон.	
ТЭЗҮ, нарийвчилсан зураг төсөл, төслийн бэлтгэл ажил хийгдсэн, УИХ, Засгийн газрын шийдвэрээр хэрэгжих нь батлагдсан.	Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойлогдоогүй.	Холбогдох шийдвэр, тогтоол болон бусад бүх материалыг шалгасны үндсэн дээр хүлээн авна. Санхүүжилтийн эх үүсвэр болон санхүүжилт шийдэх гэрээ, хэлэлцээрийн явц үнэлгээний чухал шалгуур болно.
	Санхүүжилтийн эх үүсвэр тодорхойлогдсон ч, шийдвэрлэгдээгүй.	
	Санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдэн, хэзээнээс гүйцэтгэл гаргах нь тодорхой болсон.	

Эдгээр асуудлыг бичиг баримтад тулгуурлан нягталж үзэхээс гадна ТЭЗ-аас авсан тодруулга дээр үндэслэн үнэлгээг хийнэ. Гэхдээ эцсийн шийдвэрийг гаргахдаа "нотолгоонд суурилсан" (evidence base) байх зарчмыг баримтална. Жишээлбэл, ТЭЗУС, ТЭЗҮ хийгдэж байгаа гэдэг нь шийдвэр гаргах үндэс болохгүй, зайлшгүй ТЭЗУС, ТЭЗҮ-ийн тайлан, эсвэл түүнийг батлах бичиг баримт байж төслийн төлөвлөлт болон бэлтгэл ажлын талаар бодитоор тодорхойлно.

Төсвийн тухай хуулийн 28-р зүйлийг нягталж үзвэл 30 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй төсөл санхүүгийн эх үүсвэрээс үл хамааран (улсын төсөв, хандивлагч, ТХХТ, хувийн хэвшил) УХОХ-т тусгагдсаны дараа хэрэгжүүлж эхлэх боломжтой болох хэдий ч бодит байдал дээр жилийн төсөв (улсын төсөв, гадаадын зээл тусламж) болон хандивлагч, хувийн хэвшилтэй хийсэн гэрээ хэлэлцээрээр (гадаадын зээл тусламж, ТХХТ, хувийн хэвшил) УХОХ-т тусгагдахаас өмнө төсөл боловсруулах, бэлтгэл ажил, санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдсэн байдаг. Иймэрхүү нөхцөл байдалд Төсвийн тухай хуулийг нарийн баримтлах нь төвөгтэй тул Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага дээрх хүснэгтэд дурьдсан шинэ төслүүдийн нөхцөл байдлыг сайтар тодорхойлох нь дараагийн (2) төслийн үнэлгээ, (3) төслийг эрэмбэлэлт, (4) УХОХ-т тусгах ажилд дөхөм болно.

УХОХ-т тусгуулах төслийн санал тавигдсан үед төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрээр жагсаалт гарган Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдээлэл хүргүүлнэ. Ингэснээр дээрх хүснэгтэд дурьдсан нөхцөл байдлыг Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зүгээс тодруулах боломж бүрдэнэ. Түүнчлэн санал ирүүлсэн байгууллагуудын төслийн агуулгын (санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн эсэх гм) талаар нэмэлт тодруулга аван, тухайн жилд УХОХ-т тусгагдаагүй хэдий ч Улсын төсөв, Гадаадын зээл тусламж зэргээр хэрэгжих төсөл байгаа эсэхийг (шууд Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагаруу санал ирүүлсэн) давхар нягтална.

1.2. УХОХ-т тусгах хөрөнгө оруулалтын төслийг үнэлэх

Төслийн санал хүлээн авсны дараа аргачлалын дагуу төслийн үнэлгээг хийнэ. Өмнө дурьдсанчлан, тухайн төсөл дээр дурьдсан аль нөхцөл байдалд байгааг тодорхойлох хэрэгтэй хэдий ч үнэлгээ хийж эхэлсэн бол зарчмын хувьд дээрх аль нөхцөлд байсан ч тогтсон, объектив хэм хэмжээнээс үнэлгээ хийх шаардлагатай. Тухайн төслийн үнэлгээ "Урьдчилсан үнэлгээ" болон "Иж бүрэн үнэлгээ" гэсэн 2 үе шаттай байх бөгөөд үнэлгээний явцад тухайн төслийг бусад төсөлтэй харьцуулахгүй байх нь чухал.

Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь ТЭЗ-аас аргачлалын дагуу үнэлсэн үр дүнг нягтлахын дээр бие даасан байр сууринаас үнэлгээ хийнэ. Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын бие даасан байр суурь гэдэг нь 1) Улсын хөгжилд тэргүүлэх ач холбогдолтой эсэх, 2) салбар хоорондын уялдааг хангасан эсэх гэсэн 2 асуудал дээр тулгуурлана.

Төслийн "Урьдчилсан үнэлгээ"-г Хавсралт 6-т заасан маягтын дагуу хийнэ. Энэхүү үнэлгээнээс төслийг а) иж бүрэн үнэлгээ хийх шаардлагагүй, нэн тэргүүнд хэрэгжүүлэх б) иж бүрэн үнэлгээ хийх шаардлагагүй, хасах в) иж бүрэн үнэлгээний шатанд шилжүүлэх гэсэн 3 ангилалд хуваан Хавсралт 7-т заасан маягтын дагуу нэгдсэн тайлан гарган, баталгаажуулна.

"Урьдчилсан үнэлгээ"-ны шатнаас иж бүрэн үнэлгээний шатанд шилжүүлэхээр шийдвэрлэсэн төслүүдэд энэхүү гарын авлагын 3 бүлэгт тодорхой заасны дагуу "Иж бүрэн үнэлгээ" хийнэ.

Төслийн иж бүрэн үнэлгээ нь а) Төсвийн ерөнхийлөн захирагч, б) Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гэсэн хоёр талын бие даасан үнэлгээнээс тогтоно.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь "Улсын хөрөнгө оруулалтын төслийг үнэлэх, эрэмбэлэх гарын авлага"-ыг ашиглан заагдсан маягтын дагуу төсөл нэг бүрээр үнэлгээ хийх ба уг үнэлгээндээ үндэслэн энэ аргачлалын 3.4 хэсэгт заасны дагуу төслүүддээ эрэмбэ тогтоон хүргүүлнэ.

Төслийн иж бүрэн үнэлгээ хийх арга зүй нь а.Төслийн ач холбогдол, б.Төслийн хэрэгжих боломж гэсэн 2 хэмжээстэй байх ба хэмжээс тус бүр 6, нийт 12 үндсэн шалгуур үзүүлэлт, 42 дэд шалгуур үзүүлэлтээс бүрдэх ба үнэлгээний үндсэн арга нь оноо өгөх арга байна.

Эдгээр үнэлгээний аргыг энэхүү гарын авлагын 3 дугаар бүлэгт дэлгэрэнгүй тайлбарлана.

Төслийн үнэлгээний шатанд УХОХ-т санал ирүүлсэн байгууллагуудаас шаардлагатай мэдээллийг тодруулах ажил хийгдэх бөгөөд энэ нь ч санал хүлээн авах үетэй адил нотолгоонд суурилсан үнэлгээ байна. Эдгээр нь дээр дурдсанчлан бичиг баримт бүрэн эсэхийг шалгах агаас гадна төслийн санал болон иж бүрэн үнэлгээ дээрх агуулгыг мөн ижил зарчмаар үнэлнэ гэсэн үг. Төслийн санал авах маягт болон холбогдох бичиг баримт дээрх агуулгыг давхар нягталж, нэмэлт өөрчлөлт хэрэгцээтэй бол тухайн ТЕЗ-д албан ёсоор санал тавих шаардлагатай.

1.3. УХОХ-т тусгах хөрөнгө оруулалтын төслүүдийг эрэмбэлэх, сонгох

Төслийн үнэлгээний дүнд тулгуурлан тухайн төсөл бүрийн "Ач холбогдол" болон "Хэрэгжих боломж"-ийг тус бүрийн үнэлгээний шалгуурт тулгуурлан үр дүнг гаргана. Онооны дүнд тулгуурлан төсөл бүр дээр яагаад ийм оноо авсан (илүү оноо авахын тулд яаж сайжруулах хэрэгтэй) тухай үнэлгээний ерөнхий дүгнэлтийг бичиж тэмдэглэн, санал гаргасан байгууллагад хүргүүлнэ.

Төслийн иж бүрэн үнэлгээ хийгдсэний дараа төслийг эрэмбэлнэ. Төслийг эрэмбэлэх гэдэг нь Хязгаарлагдмал нөөц боломжийн хүрээнд үлсын хөгжлийн зорилтод хүрэхийн тулд аль төслийг тэргүүн ээлжинд хэрэгжүүлэх вэ гэдгийг шийдвэрлэнэ гэсэн үг юм. Гэхдээ нарийвчилбал зөвхөн УХОХ-т тусгагдсан төслүүд дунд эрэмбэ тогтоох төдийгүй улсын төсөв, гадаадын зээл тусламж, ХХХТ, хувийн хэвшил (банкны даатгал орно), тухайн жилээс хойших төсвийн хүрээ зэргийг харгалзан үзэж байж тэрхүү хязгаар дотор илүү хэрэгжих боломж, эрэмбэ өндөртэй төслийг сонгон шалгаруулна. Эрэмбэлэх чиг хандлага, хязгаар жил болгоны төсөв, өр, зээлийн хязгаараас шалтгаалан өөрчлөгдөх тул урьдчилан эдийн засгийн шинэчилсэн таамаг болон Дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, эсвэл Засгийн газрын үндсэн чиглэлд тулгуурлан Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хооронд хэлэлцээр хийн тухайн санхүүгийн эх үүсвэрт тулгуурласан "гэртүүлэх хүрээ"-г гаргаж ирэх шаардлагатай болно.

Эдгээр нөхцөлтэй төслийг эрэмбэлэхэд 2 зүйлийг шийдвэрлэх хэрэгтэй. Үүнд, 1) УХОХ-т тусгах шаардлагатай эсэхийг шийднэ, эсвэл 2) төслийн ач холбогдол болон хэрэгжих боломжийг харгалзан УХОХ-т тусгах хэрэгтэй төсөл хэдий ч УХОХ-ийн хэрэгжих хугацаанд хэрэгжүүлэх эсэх, хэзээ хэрэгжүүлэхийг шийдвэрлэх гэсэн 2 асуудал байна. Эдгээрийн талаар доор дэлгэрэнгүй тайлбарлав.

1) **УХОХ-т тусгах шаардлагатай эсэхийг шийдвэрлэх.** Санхүүгийн эх үүсвэр тус бүрийн төсвийн хэмжээг харгалзан тухайн жилийн УХОХ-т шинээр тусгагдах төслийн хэмжээг (тоо болон төсөв) тогтсоны үндсэн дээр шинээр тусгуулахаар ирүүлсэн төслийн саналаас хамгийн тохиромжтойг сонгон шалгаруулна. Энэ нь санхүүгийн эх үүсвэр нь хэдийнээ шийдэгдсэн төсөл дээр яригдах бөгөөд санхүүгийн эх үүсвэр нь шийдэгдээгүй төсөл нь тухайн жилээс эхлэх эсэхийг шийдэх талаас харахад УХОХ-ийн жагсаалтаас хасагдана.

Тогтсон санхүүжилтийн эх үүсвэр дундаас төслийг эрэмбэлэх өөрөөр хэлбэл харьцуулсан үнэлгээ хийхэд санхүүгийн эх үүсвэр төдийгүй эдийн засаг, нийгэм, улс төрийн нөхцөл байдлыг харгалзсан шийдвэр гаргах шаардлагатай. Үүнд, (а) Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дотоод саналыг (эвсэл хувилбар) эрэмбэлэх үндэслэлийн хамт урьдчилан бэлдэх, (б) төслийн үнэлгээ хийгдсэний дараах шатанд санхүүжилтийн эх үүсвэр болон төсвийн хүрээний холбогдох асуудалтай нь хамт Засгийн газарт хүргүүлэх гэсэн 2 арга байна (а) арга хамгийн оновчтой хэдий ч бодит байдал дээр (б) явцын дунд зохицуулалт хийх эсвэл (а,б)хослуулах байдлаар төслийг эрэмбэлж болно.

2) УХОХ-т тусгуулах цаг хугацааны талаар шийдвэрлэх. Хэдэн жил үргэлжлэх улсын хөрөнгө оруулалтын хандлагыг тодорхойлох УХОХ-ийн жагсаалтад Төсвийн ерөнхийлөн захирагчийн (эсвэл хэд хэдэн салбар дамнасан төсөл) стратеги бодлогоор шууд хэрэгжүүлэх төсөл биш хэдий ч УХОХ хэрэгжих хугацаанд эхлүүлэх ач холбогдолтой гэдэг байр сууринаас оруулсан төсөл байж болно. Иймд УХОХ хэрэгжих хэдэн жилийн турш төсөл хоорондын эрэмбэ хуваарилалтыг хэлэлцэх шаардлага гарна. Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага энэхүү төсөл эрэмбэлэх энэ боломжийг ашиглан Төсвийн ерөнхийлөн захирагч болон хэдэн хэдэн төсвийн ерөнхийлөн захирагчтай энэхүү хуваарилалт эрэмбийн талаар хэлэлцүүлэг хийх боломжтой. Шинээр тусгуулах төслүүд дунд төсөл хүлээн авах үед бэлтгэл ажлууд хийгдэж дуусаагүй, эсвэл санхүүгийн эх үүсвэр тодорхойлогдон, шийдвэрлэгдээгүй төсөл олон байдаг тул үнэлгээний дүгнэлтэд тулгуурлан тэргүүлэх эрэмбэ тогтоох хэлэлцүүлэг хийснээр тухайн жил төдийгүй УХОХ хэрэгжих хугацаан дахь тэргүүлэх эрэмбэ тогтоох болон түүний зохицуулалт хийх боломжтой.

1.4. УХОХ-т тусгагдсан төслийн хэрэгжилтийг хянах

Өмнө жилүүдэд УХОХ-т тусгагдсан “Шилжин ирэх төсөл” дотроос төслийг үргэлжлүүлэх эсэхийг (дараагийн жилийн УХОХ-т тусгах эсэх) шийдвэрлэхэд төслийн хяналт шинжилгээ чухал ач холбогдолтой. “Шилжин ирэх төсөл” нь дараах 3 төрөлд хуваагдана.

- Өмнөх жилүүдэд УХОХ-т тусгагдсан бөгөөд хэрэгжиж буй төслүүд
- Өмнөх жилүүдэд УХОХ-т тусгагдсан, тухайн жилд эхлэх төлөвлөгөөтэй санхүүгийн эх үүсвэр шийдэгдсэн хэдий ч үйл ажиллагаа нь эхлээгүй төсөл, УХОХ-т тухайн жил эхлэх төлөвлөгөөтэй байсан ч санхүүжилт хийгдээгүй эсхүл санхүүгийн эх үүсвэр шийдэгдээгүй тул үйл ажиллагаа эхлээгүй төслүүдийг “шинээр эхлэх төсөл” хэмээн дахин үнэлгээ хийх шаардлагатай төсөл
- Өнөөг хүртэл УХОХ-т тусгагдаагүй байсан 30 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй, үйл ажиллагаа нь хэдийнээ эхэлсэн төсөл (эсхүл УХОХ-ийн тодотгол хийх үед “шилжин ирэх төсөл” гэсэн тодотголтой)

Дээр дурдсанчлан энэхүү хяналт шинжилгээний гол зорилго нь хэрэгжиж буй төслүүдийг дараагийн УХОХ-т тусгах эсэхийг шийдвэрлэх юм. Хяналт шинжилгээ нь төслийн үйл ажиллагааны явцыг хянах үйл ажиллагааны хяналт шинжилгээ болон санхүүжилтийн гүйцэтгэлийн явц болон нийт өртгийг хянах санхүүгийн хяналт шинжилгээ гэсэн 2 талтай. Аль аль нь төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагааг (үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл) тухайн жилийн төлөвлөлтийн дагуу хэрэгжиж буй эсэхийг хянах явцын хяналт шинжилгээг гол цөм болгон нэгтгэн, төслийн хүрэх үр дүн болон төслийн зорилгод хүрсэн эсэхийг хүрэх үр дүнгийн хяналт шинжилгээ, дотоод гадаад эрсдэлийг хянах эрсдэлийн хяналт шинжилгээний өгөгдлийг агуулсан байна.

1.5. УХОХ боловсруулах

Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь 3.2-т дурдсан шинээр тусгах төслийн үнэлгээний дүн болон зөвшилцөл эсхүл 3.3-т дурдсан

шилжин ирэх төслийн хяналт шинжилгээний дүнг нэгтгэсэн тайланд үндэслэн УХОХ-ийг эцэслэж боловсруулна. Эцэслэн боловсруулахад 1) Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хийх хэлэлцүүлэг, зөвшилцөл 2) Төсвийн ерөнхийлөн захирагчидтай хийх хэлэлцүүлэг 3) Засгийн газрын түвшин дэх зөвшилцөлд тулгуурлана.

1) **Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хийх хэлэлцүүлэг, зөвшилцөл.** Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хийх хэлэлцүүлэг, зөвшилцөл дээр гол нь тухайн жилийн нийт төсвийн хязгаар, хуваарилалтыг дахин тодруулах шаардлагатай. Шинээр тусгагдах болон шилжин ирэх төслүүдийг нэгтгэсэн УХОХ-ийн жагсаалт нь эдийн засаг, санхүүгийн нөхцөл байдалд тохирсон байгаа эсэхийг Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шат дараалан нягтлан, зохицуулалт хийн, УХОХ өргөн барих үед хэрэгжих боломжтой санхүүгийн хязгаарт суурилсан байхаар анхаарна. Түүнчлэн УХОХ боловсруулахдаа улсын төсөв эсхүл гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төсөл УХОХ-т тусгагдсан эсэхийг давхар нягтална.

2) **Төсвийн ерөнхийлөн захирагчидтай хийх хэлэлцүүлэг.** Шинээр санал ирүүлсэн төслийн тухайд ялангуяа тухайн жилд эхлэх төслийн боловсруулалтын түвшин (үнэлгээний дүн) болон санхүүгийн эх үүсвэр баттай шийдвэрлэгдэх гэсэн 2 шалгуур шийдэгдсэн байх шаардлагатай. Санал хүлээн авах үед бүрдүүлэлт дутуу, бэлтгэл ажил хийгдээгүй байх тохиолдолд энэхүү шатанд дахин лавлах хэрэгтэй. Энэ үед тухайн жилийн (дараагийн жилийн) хийгдэх арга хэмжээнд оруулж амжихгүй, эсхүл санхүүгийн талаарх эцсийн шийд нь тодорхойгүй төслийн тухайд төслийн эхлэх хугацааг нь хойшлуулах уу, УХОХ-т тусгахгүй байх уу гэдгийг зохицуулах хэрэгтэй.

3) **Засгийн газар доторх зөвшилцөл.** УХОХ-ийн саналыг Засгийн газарт өргөн барихаас өмнө урьдчилсан байдлаар УХОХ саналыг хүргүүлэн Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд зөвшилцөл хийнэ. Энэ үед Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь "ижил байр сууринаас" Төсвийн ерөнхийлөн захирагчидтай хэлэлцүүлэг, зөвшилцөл хийхээр урьдчилан зохицуулалт хийсэн байна.

Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын байр сууринаас шинээр санал ирсэн төслийн үнэлгээний дүн болон эрэмбийн талаар тайлбар хийнэ. Засгийн газрын өгсөн чиглэл, шийдвэрээр шинээр төсөл тусгуулахаар болсон тохиолдолд, Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага тухайн төслийн санал гаргасан Төсвийн ерөнхийлөн захирагчид тухайн төслийн агуулга, боловсруулалтыг сайжруулах хүсэлт тавих, шаардлагатай бол зохих дэмжлэг үзүүлнэ. Санхүүгийн эх үүсвэрийн тухайд Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрх мэдлийн хүрээнд зохицуулалт, зөвшилцөл хийн шаардлагатай тохиолдолд Засгийн газрын шийдвэрийг дагана.

1.6. УХОХ-т тусгагдсан төслийн хэрэгжилтийг хянах

Өмнө жилүүдэд УХОХ-т тусгагдсан "Шилжин ирэх төсөл" дотроос төслийг үргэлжлүүлэх эсэхийг (дараагийн жилийн УХОХ-т тусгах эсэх) шийдвэрлэхэд төслийн хяналт шинжилгээ чухал ач холбогдолтой. "Шилжин ирэх төсөл" нь дараах 3 төрөлд хуваагдана.

- Өмнөх жилүүдэд УХОХ-т тусгагдсан бөгөөд хэрэгжиж буй төслүүд
- Өмнөх жилүүдэд УХОХ-т тусгагдсан, тухайн жилд эхлэх төлөвлөгөөтэй санхүүгийн эх үүсвэр шийдэгдсэн хэдий ч үйл ажиллагаа нь эхлээгүй төсөл, УХОХ-т тухайн жил эхлэх төлөвлөгөөтэй байсан ч санхүүжилт хийгдээгүй эсхүл санхүүгийн эх үүсвэр шийдэгдээгүй тул үйл ажиллагаа эхлээгүй төслүүдийг "шинээр эхлэх төсөл" хэмээн дахин үнэлгээ хийх шаардлагатай төсөл

- Өнөөг хүртэл УХОХ-т тусгагдаагүй байсан 30 тэрбум төгрөгөөс дээш өртөгтэй, үйл ажиллагаа нь хэдийнээ эхэлсэн төсөл (эсхүл УХОХ-ийн тодотгол хийх үед "шилжин ирэх төсөл" гэсэн тодотголтой)

Дээр дурдсанчлан энэхүү хяналт шинжилгээний гол зорилго нь хэрэгжиж буй төслүүдийг дараагийн УХОХ-т тусгах эсэхийг шийдвэрлэх юм. Хяналт шинжилгээ нь төслийн үйл ажиллагааны явцыг хянах үйл ажиллагааны хяналт шинжилгээ болон санхүүжилтийн гүйцэтгэлийн явц болон нийт өртгийг хянах санхүүгийн хяналт шинжилгээ гэсэн 2 талтай. Аль аль нь төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагааг (үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл) тухайн жилийн төлөвлөлтийн дагуу хэрэгжиж буй эсэхийг хянах явцын хяналт шинжилгээг гол цөм болгон нэгтгэн, төслийн хүрэх үр дүн болон төслийн зорилгод хүрсэн эсэхийг хүрэх үр дүнгийн хяналт шинжилгээ, дотоод гадаад эрсдэлийг хянах эрсдэлийн хяналт шинжилгээний өгөгдлийг агуулсан байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. УХОХ-Т ТУСГАХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСЛИЙН САНАЛ ХҮЛЭЭН АВАХ, МЭДЭЭЛЛИЙГ НЯГТЛАН ШАЛГАХ

Төсвийн ерөнхийлөн захирагч нь "Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төсөл боловсруулах аргачлал", түүний холбогдох зааварчилгааны дагуу төслийн саналаа боловсруулж, төслийн санал авах маягыг холбогдох судалгаа, шинжилгээний материалын хамт Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ. Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь эхний шатанд төслийн материалын иж бүрдлийг тус аргачлалын Хавсралт 4 "Төслийн материалын бүрдлийг шалгах хуудас"-ын дагуу нягтлан, материал дутуу байвал үнэлгээ хийхээс татгалзаж, энэ тухай ТЕЗ-д эргэн мэдэгдэх эсхүл нэмэлтээр ирүүлэхийг хүсэж нөхөн бүрдүүлэлт хийнэ.

Дараагийн шатанд төслийн санал авах маягыг холбогдох аргачлалын дагуу бүрэн бөглөсөн эсэхийг Хавсралт 5 дахь "Төслийн саналын маягтуудын мэдээлэл шаардлага хангаж буй эсэхийг нягтлах хуудас"-ын дагуу нягталж, шаардлагатай мэдээлэл төслийн санал авах маягтад оновчтой, бүрэн туссан эсэхэд дүгнэлт хийнэ. Төслийн саналын маягтуудад дахь хариулсан хариултын тоо нь нийт асуултын 50 хувьд хүрэхгүй байвал үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээлэл "хангалтгүй" гэж үзэн, уг төслийг үнэлэхээс татгалзаж энэ тухай ТЕЗ-д "Эргэн мэдэгдэх эсхүл гүйцээн ирүүлэх"-ийг хүснэ. Төслийн санал авах маягтын нийт асуултыг харгалзах үнэлгээний шалгуур үзүүлэлт тус бүрээр болон лавлагаа, мэдээллийн шинж чанараас нь хамаарч 4 үндсэн төрөлд ангилан авч үзэх ба асуултын төрөл тус бүрээр хангалттай хариулсан эсэхэд дүгнэлт гаргана.

1) Төслийн материалын бүрдлийг шалгах хуудас

Төслийн материалын иж бүрдлийг шалгах хуудас нь 1. Урьдчилсан үнэлгээний хуудас, 2. Төслийн санал авах маягт, 3. Хавсралт 4. ТЕЗ-ийн иж бүрэн үнэлгээний хуудас, 5. Төслийн иж бүрэн үнэлгээ, эрэмбийн нэгдсэн дүгнэлт гэсэн таван үндсэн хэсгээс бүрдэх ба ТЕЗ нь тус бүрийн бүрдлийг, бөглөсөн эсэх, хавсаргасан эсэх, ирүүлсэн эсэх зэргийг шалган холбогдох хэсгээс шаардлагатай сонголтуудыг хийн, тайлбарын хамт ирүүлнэ. Уг хуудас дээр үндэслэн Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага хүснэгтийн сүүлийн баганад үзүүлсний дагуу нягталж, шаардлагатай нөхөн бүрдүүлэлтийг хийн, дараагийн шатанд шилжүүлнэ.

Төслийн материалын бүрдлийг шалгах хуудас

ТЭЗ:

Төслийн нэр:

№	Бичиг баримт	Бүрдэл	ТЭЗ-ийн шалгасан байдал	Тайлбар	Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын хянасан байдал	
1	Төслийн товч танилцуулга	Төслийн гол агуулга, ач холбогдол, төслийн хүрээнд хийгдэх болон хийгдсэн ажлуудыг багтаан танилцуулна.				
2	Төслийн судалгаануудын хураангуй	Төсөл хөгжүүлэлтийн хүрээнд өмнө нь хийгдсэн судалгаануудын /суурь судалгаа, ТЭЗУС, ТЭЗҮ, БОНБУ г.м./ хураангуй танилцуулгыг 30 хүртэл хуудсанд багтаан бэлтгэнэ.				
3	Төслийн санал	1	Хүснэгт. 1 Төслийн үндсэн мэдээлэл	Ж:бөвлөсөн		
		2	Хүснэгт. 2 Бодлогын уялдаа, хууль зрх зүйн орчин			
		3	Хүснэгт. 3 Санхүүжилт болон төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө			
		4	Хүснэгт. 4 Төслийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт			
		5	Хүснэгт. 5 Төслийг хэрэгжүүлэх бэлтгэл хангагдсан байдал			
		6	Хүснэгт. 6 Төслийн дэд бүтцийн хэрэгцээ			
		7	Хүснэгт. 7 Нийгэм, эдийн засгийн үр ашгийн шинжилгээ			
		8	Хүснэгт. 8 Санхүүгийн шинжилгээ			
			8-1. Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал (Санхүүгийн шинжилгээ)			
			8-2. Зардлын задаргаа (Санхүүгийн шинжилгээ)			
8-3. Зардлын тооцоолол (Санхүүгийн шинжилгээ)						
9	Хүснэгт. 9 Эдийн засгийн шинжилгээ					
	9-1. Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал (Эдийн засгийн шинжилгээ)					
	9-2. Үр ашгийн тооцоолол (Эдийн засгийн шинжилгээ)					
10	Хүснэгт. 10 Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн төслийн хэрэгжилтийн тайлангийн хүснэгт		Ж:бөглөөгүй			
4	Төслийн үнэлгээний дүгнэлт	1	Урьдчилсан үнэлгээний хуудас	Ж:бөглөсөн	Ж:дутуу нөхөн бүрдүүлэх	
		2	Урьдчилсан үнэлгээний нэгдсэн дүгнэлт			
		3	Төсвийн ерөнхийлөн захирагчийн иж бүрэн үнэлгээний хуудас			
		4	Төслийн иж бүрэн үнэлгээ, эрэмбийн нэгдсэн дүгнэлт			
5	Бусад судалгаа, тооцоонууд	1	Суурь судалгаа			
		2	Бодлогын судалгаа			

	3	ТЭЗУС	Ж: хавсаргасан			
	4	ТЭЗҮ				
	5	Зураг төсөл				
	6	БОНБУ (ерөнхий)				
	7	БОНБУ (нарийвчилсан)				
	8	Газрын гэрчилгээ				
	9	Холбогдох тусгай зөвшөөрлүүд				
	10	Инженерийн судалгаа				
	11	Төслийн хүрээнд байгуулагдсан гэрээ, хэлэлцээрийн хуулбар				
	12	Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөө				
	13	Эрсдлийн шинжилгээ				
	14	Мөнгөн урсгал / Санхүүгийн тайлан	Ж: хавсаргасан			
	15	Санхүүгийн шинжилгээ (Санхүүгийн өгөөжийн дотоод хувь)				
	16	Эдийн засгийн шинжилгээ (Эдийн засгийн өгөөжийн дотоод хувь)	Ж: Үгүй			
	Үндэсний хөгжлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагын дүгнэлт					

Зураг 2.1 Төслийн материалын бүрдлийг шалгах хуудас

- 2) Төслийн саналын маягтуудын мэдээлэл шаардлага хангаж буй эсэхийг нягтлах хуудас
- Төслийн саналын маягтуудын мэдээлэл шаардлага хангаж буй эсэхийг нягтлах хуудас нь төслийн санал авах маягтын нийт 10 хүснэгт дэх харгалзах асуултыг тус бүр нэршлийн дагуу төрлөөр нь ангилах боломжтой байдлаар жагсаасан байх ба Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хариуцсан албан хаагч асуулт бүрэн бөглөгдсөн эсэх, мэдээлэл нь шалгуур үзүүлэлтийн шаардлага хангаж буй эсэхийг нягталж, шаардлага хангасан төслийг иж бүрэн үнэлгээ хийх шатанд шилжүүлнэ.

Төслийн саналын маягтуудын мэдээлэл шаардлага хангаж буй эсэхийг нягтлах хуудас							
№	Малгын нэр	Асуулт		Бөглөсөн эсэх	Шаардлага хангаж буй эсэх	Гайлбар	
		Нэр	Төрөл				
1	Төслийн үндсэн мэдээлэл	Төслийн нэр		Ж: Лавлагаа			
		Төсөл хэрэгжих салбар					
		Төсөл хэрэгжих дэд салбар					
		Төсөл хэрэгжих байршил					
		Төслийн үндэслэл, шаардлага					
		Төслийн танилцуулга					
		Төслийн хүрээнд барьж байгуулах барилга байгууламж / тоног төхөөрөмж / үйл ажиллагаа					
		Хөрөнгө оруулалтаар бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээ	Бүтээгдэхүүн, үйлчилгээний агуулга, зах зээлийн өнөөгийн төлөв байдал				
			Нийгмийн эрэлт хэрэгцээ, шаардлага				
			Эдийн засгийн эрэлт, хэрэгцээ, шаардлага				
		Дэд бүтцийн хэрэгцээ, шаардлага					
Бүтээн байгуулалтын зардлын эх үүсвэр							
Төслийн нийт төсөвт өртөг							

Төслийн болон ашиглалтын хүчин чадал	Төслийн нийт хүчин чадал болон хэмжих нэгж				
	Төлөвлөж буй ашиглалтын хүчин чадал				
Төслийн хэрэгжих хугацаа	Бүтээн байгуулалт				
	Ашиглалтанд орсноос хойш				
Хөгжлийн бодлогын зорилго, зорилттой нийцэх байдал	Урт хугацааны хөгжлийн бодлого				
	5 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлого				
	10 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлого				
	Бүс, орон нутгийн хөгжлийн бодлого				
Бусад төсөл, арга хэмжээтэй уялдах байдал	УХОХ-т туссан бусад төсөл, арга хэмжээтэй уялдах байдал				
	УХОХ-т тусаагүй төсөл, арга хэмжээтэй уялдах байдал				
Хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө	Хүрээлэн буй орчинд ээлтэй технологи				
	Хүрээлэн буй орчныг хамгаалах хариуцлагын тогтолцоо				
	Газар чөлөөлөлт				
Төслийн зорилго, зорилт	Эрхэм зорилго				
	Төслийн зорилго				
	Зорилт 1				
	Зорилт 2				
	Зорилт 3				
Санхүү, эдийн засгийн үзүүлэлтүүд	FIRR Санхүүгийн өгөөжийн дотоод хувь				
	NPV (Financial analysis) Цэвэр өнөөгийн үнэ цэнэ (Санхүүгийн)				
	B/C Үр ашиг, зардлын харьцаа (Санхүүгийн)				
	EIRR Эдийн засгийн өгөөжийн дотоод хувь				
	NPV (Economic analysis) Цэвэр өнөөгийн үнэ цэнэ (Эдийн засгийн)				
	B/C Үр ашиг, зардлын харьцаа (Эдийн засгийн)				
Төслийн нийгэм, эдийн засгийн үр ашиг	Төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээний стандартыг сайжруулахад үзүүлэх нөлөө				
	Хүний эрүүл, урт удаан амьдрахад үзүүлэх нөлөө				
	Иргэдийн мэдлэг, боловсролын түвшинг дээшлүүлэхэд үзүүлэх нөлөө				
	Иргэдийн эрүүл, аюулгүй, зохистой орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд үзүүлэх нөлөө				

		Үндэсний үнэт зүйлийг хадгалах, хамгаалах, бий болгоход үзүүлэх нөлөө				
		ЗҮАТ-нд дурдагдсан нийгмийн ач холбогдлын үзүүлэлт нь тухайн салбарын стандарт түвшинг хангах эсэх				
	Эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж	Үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэхэд үзүүлэх нөлөө				
		Экспортыг дэмжих, импортыг орлоход үзүүлэх нөлөө				
		Ажлын байрыг нэмэгдүүлэхэд үзүүлэх нөлөө				
		Иргэдийн цалин, бодит орлогыг нэмэгдүүлэхэд үзүүлэх нөлөө				
		Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд үзүүлэх нөлөө				
		ЗҮАТ-нд дурдагдсан эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийн үзүүлэлт нь тухайн салбарын стандарт түвшинг хангах эсэх				
		Хууль, эрх зүйн орчин				
		Бүтэц, зохион байгуулалт				
		Шинэ технологи, инноваци шингэсэн байдал				
		Холбогдох судалгаа, шинжилгээ				
		Дэд бүтцийн хэрэгцээ				
		Хэрэгжих боломж				
		Эрсдэл				
2	Бодлогын уялдаа, хууль эрх зүйн орчин	Хөгжлийн бодлогын баримт бичгийн зорилго, зорилттой нийцэх байдал	Урт хугацааны хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал	Ж: Ач холбогдол		
			10 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал			
			5 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал			
			Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал			
	Бусад төсөл, арга хэмжээтэй уялдах уялдаа, хамаарал	УХОХ-т туссан тухайн салбар, бүс орон нутаг дахь бусад төсөл, арга хэмжээтэй уялдах эсэх				
		УХОХ-т тусаагүй тухайн салбар, бүс орон нутаг дахь төсөл, арга хэмжээтэй уялдах эсэх				
		Уялдан хэрэгжих ямар нэг төсөл, хөтөлбөр, арга хэмжээ байхгүй бол энэ тухай тодорхой тайлбарлах				
Төслийн үндэслэл, хууль эрх зүйн орчин	Хууль эрх зүйн шаардлагад нийцэж буй байдал, төслийн үндэслэл					

3	Төслийн санхүүжилт, үйл ажиллагааны төлөвлөгөө	Бүтээн байгуулалтын үе шат	Он оноор төлөвлөсөн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө	Ж: Хэрэвж их боломж				
			Төслийн бүтэц, зохион байгуулалтын бэлэн байдал					
			Шинэ технологи					
			Учирч болох эрсдэл					
			Эрсдэл бууруулах арга хэмжээ					
			Тоног төхөөрөмж					
			Барилга					
			Цалин хөлс					
			Бусад					
			Нийт					
			Төлөвлөж буй санхүүжилтийн хувь					
		Ашиглалтанд орсноос хойш	Он оноор төлөвлөсөн төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө					
			Учирч болох эрсдэл					
			Эрсдэл бууруулах арга хэмжээ					
			Тоног төхөөрөмж					
			Барилга					
			Цалин хөлс					
			Бусад					
			Нийт					
Төслийн хүрээнд бий болох бүтээгдэхүүн, үйлчилгээ								
4	Төслийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлт	Зорилтууд						
		Шалгуур үзүүлэлтийн түвшин						
		Үнэлэх шалгуур үзүүлэлтийн нэр						
		Тайлбар						
		Суурь түвшин, өмнөх оны хэрэгжилт						
		Шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин, үр дүн						
5	Төслийн урьдчилсан судалгаа, гэрээ хэлцэл	Суурь судалгаа						
		Бодлогын судалгаа						
		ТЭЗУС						
		ТЭЗҮ						
		Зураг төсөл						
		Байгаль орчны ерөнхий/нарийвчилсан үнэлгээ						
		Газрын асуудал шийдэгдсэн эсэх						
		Холбогдох тусгай зөвшөөрлүүд						
		Бусад						
		Байгуулсан гэрээ, хэлэлцээр						
6	Төслийн дэд бүтцийн хэрэгцээ	Дэд бүтэц						
		Хэмжих нэгж						
		Нийт хэрэгцээ						
		Одоогийн байдал						
		Өргөтгөх/Шинээр барих						
		Техникийн нөхцөл авсан эсэх						
		Тайлбар						
7	Нийгэм, эдийн засгийн үр	Төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээний стандартыг сайжруулахад нөлөөлөх үү?						

ашгийн шинжилгээ	Хүний эрүүл, урт удаан амьдрахад нөлөөлөх үү?						
	Иргэдийн мэдлэг, боловсролын түвшинг дээшлүүлэхэд нөлөөлөх үү?						
	Иргэдийн эрүүл, аюулгүй, зохистой орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэхэд нөлөөлөх үү?						
	Үндэсний үнэт зүйлийг хадгалах, хамгаалах, бий болгоход нөлөөлөх үү?						
	ЗҮАТ-нд дурдагдсан нийгмийн ач холбогдлыг илтгэх үзүүлэлт нь тухайн салбарын стандарт түвшинг хангасан уу?						
	Үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх үү?						
	Экспортыг дэмжих, импортыг орлоход нөлөөлөх үү?						
	Ажлын байрыг нэмэгдүүлэхэд нөлөөлөх үү?	Бүтээн байгуулалтын үе шат	Мэргэжлийн чиглэл				
			Шууд ажлын байр				
			Шууд бус ажлын байр				
		Үйл ажиллагааны үе шат	Мэргэжлийн чиглэл				
			Шууд ажлын байр				
			Шууд бус ажлын байр				
	Иргэдийн цалин, бодит орлогыг нэмэгдүүлэхэд нөлөөлөх үү?	Бүтээн байгуулалтын үе шат	Мэргэжлийн чиглэл				
			Шууд ажлын байр				
			Шууд бус ажлын байр				
		Үйл ажиллагааны үе шат	Мэргэжлийн чиглэл				
			Шууд ажлын байр				
			Шууд бус ажлын байр				
	Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд нөлөөлөх үү?	Хөрөнгө оруулах объект					
Төлөвлөж буй хөрөнгө оруулагч							
Хэмжээ							
Мөнгөн дүн							
Нийт							
ЗҮАТ-нд дурдагдсан эдийн засгийн үр ашиг, хөрөнгийг оруулалтын өгөөжийг илтгэх үзүүлэлт нь тухайн салбарын стандарт түвшинг хангасан уу?							
8 Санхүүгийн шинжилгээ	Санхүүгийн өгөөжийн дотоод хувь	Хөрөнгө оруулалтын зардал					
		Ашиглалт, засвар үйлчилгээний зардал					
		Нийт өртөг					
		Нийт орлого					
		Цэвэр орлого/ Алдагдал					
		Хорогдуулсан мөнгөн урсгал					
		ЦӨҮЦ-ийг тооцох хорогдуулалтын хувь					
	Үр ашиг, зардлын харьцаа						
	Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал	Төслийн хүрээнд хийгдэх ажлууд					
		Нийт зардал					
	Хөрөнгө оруулалтын	Хийгдэх ажлууд					
		Нэгж					
		Хэмжээ					

		зардлын задаргаа	Нэгжийн үнэ					
			Зардал					
			Дун					
		Зардлын тооцоолол	Ашиглалт, засвар үйлчилгээний зардал					
			Аргачлал 1					
			Аргачлал 2					
		Орлогын тооцоолол	Орлогын тооцоолол					
			Орлогын задаргаа					
9	Эдийн засгийн шинжилгээ	Эдийн заогийн өгөөжийн дотоод хувь	Хөрөнгө оруулалтын зардал					
			Ашиглалт, засвар үйлчилгээний зардал					
			Нийт өртөг					
			Нийт орлого					
			Цэвэр орлого/ Алдагдал					
			Хорогдуулсан мөнгөн урсгал					
			ЦӨҮЦ-ийг тооцох хорогдуулалтын хувь:					
		Үр ашиг, зардлын харьцаа						
		Шаардлагатай хөрөнгө оруулалтын зардал	Төслийн хүрээнд хийгдэх ажлууд					
			Нийт зардал					
Үр ашгийн тооцоолол	Үр ашгийн тооцоолол							
		Үр ашгийн задаргаа						
10	Төслийн хэрэгжилтийн тайлангийн хүснэгт	Ажлын явц						
		Төслийн ажлын явцын үнэлгээ	Ажлын явц, тайлбар					
			Төслийн зорилго, зорилтыг биелүүлэхэд учирч буй саад бэрхшээл, эрсдэл					
		Санхүүжилтийн гүйцэтгэл						
		Санхүүжилтийн гүйцэтгэлийн үнэлгээ	Санхүүжилтийн гүйцэтгэл, тайлбар					
Төслийн санхүүжилттэй холбоотой учирч буй саад бэрхшээл, эрсдэл								
		ТЭЗ-ийн нэгдсэн дүгнэлт						
Шаардлага хангасан асуулт				Тоо	Хувь			
Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын дүгнэлт				<input type="checkbox"/> Үнэмэлтэй таамаглах <input type="checkbox"/> Гүйцрэн ирдэгжээгүй хүснэгт <input type="checkbox"/> Хангалттай бөгөөд				

Зураг 2.1 Төслийн саналын маягтуудын мэдээлэл хангаж буй эсэхийг нягтлах хуудас

Хүснэгт 2.1 Материалын бүрдэл

Бичиг баримт	Материал хүлээн авахад анхаарах зүйлс
Урьдчилсан үнэлгээний хуудас	ТЭЗ-аас ирүүлсэн төслийн саналын материалыг нягтлан, тухайн төслийн зорилго үндэсний аюулгүй байдал, олон улсын гэрээ, конвенцын аливаа үүрэгтэй зөрчилдөх эсэх, хүрээлэн буй орчинд ноцтой хор хөнөөлтэй эсэх, яаралтай авах арга хэмжээ эсэхийг хянан нягтлахаас гадна ТЭЗУС, ТЭЗҮ болон холбогдох судалгаа бүрэн гүйцэд хийгдсэн эсэхийг тогтсон үзүүлэлтийн дагуу шалгана. Энэхүү үнэлгээнээс төслийг а) иж бүрэн үнэлгээ хийх шаардлагагүй, нэн тэргүүнд хэрэгжүүлэх б) иж бүрэн үнэлгээ хийх шаардлагагүй, хасах в) иж бүрэн үнэлгээний шатанд шилжүүлэх гэсэн 3 ангилалд хуваана.
Материалын бүрдэл шалгах хуудас	Энэхүү шалгах хуудсыг ашиглан УХОХ-т тусгах төслийн санал боловсруулах аргачлалд заасан "Төслийн баримт бичиг"-ийн

	бүрдүүлбэрийг хангасан эсэхийг Хавсралт 1-р тулгана.
Саналын маягт	"Төслийн санал"-ыг Хавсралт 1-10-т үзүүлсэн маягтуудын дагуу бөглө, мэдээллийг бүрэн гүйцэд, үнэлгээний оноо өгөхөд хангалттай нотолгоо болж чадах үнэн бодит мэдээлэл ирүүлсэн эсэхийг Хавсралт 2-р нягтална.
Үнэлгээний хуудас (оноо, эрэмбэ)	Саналын маягт агуулгын дагуу үнэлэгдсэн эсэхийг нягтална. Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хийсэн иж бүрэн үнэлгээний дүнтэй 50 хувиар зөрүүтэй тохиолдолд зөвшилцөл хийнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. УХОХ-Т ТУСГАХ ТӨСЛИЙГ ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

3.1 УХОХ-т тусгах төслийн үнэлгээний үе шат

Аргачлалд тусгагдсаны дагуу төслийн үнэлгээ нь Төсвийн ерөнхийлөн захирагч болон Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын хийх үнэлгээ хоёр хэсэгтэй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчид төсөлд 1) оноо өгч, 2) эрэмбэлээд төслийн саналын маягтыг Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлнэ. Төсвийн ерөнхийлөн захирагчдын үнэлгээнд үндэслэн Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь 1) Төсвийн ерөнхийлөн захирагчдаас ирүүлсэн материалын иж бүрдлийг Хавсралт 4-ийн дагуу нягтлан, материал дутуу байвал үнэлгээ хийхээс татгалзаж, энэ тухай эргэн мэдэгдэх эсхүл нэмэлтээр ирүүлэхийг хүсэж нөхөн бүрдүүлэлт хийнэ. 2) "Төслийн саналын маягт"-ыг холбогдох аргачлалын дагуу бүрэн бөглөсөн эсэхийг аргачлалын Хавсралт 5-ын дагуу нягтална. Төслийн саналын маягтууд дахь хариултын тоо нь нийт асуултын 50 хувьд хүрэхгүй байвал үнэлгээ хийхэд шаардлагатай мэдээлэл хангалтгүй гэж үзэн уг төслийг үнэлэхээс татгалзаж энэ тухай эргэн мэдэгдэх эсхүл гүйцээн ирүүлэхийг хүснэ. 3) Төслийн саналын маягтууд дах мэдээллүүдийг асуулт нэг бүрээр нягтлан, ирүүлсэн мэдээлэл нь утга, найруулга, үг хэллэгийн хувьд тухайн төслийн талаар хангалттай мэдээлэл өгөхүйц байгаа эсэх, асуултын утгыг зөв ойлгон бүрэн хариулсан эсэх, хариултууд нь мэдээллийн зөрүүтэй байгаа эсэхийг аргачлалын Хавсралт 4-ийн дагуу тодорхойлно. Хэрэв нягталж үзэхэд шаардлага хангаж буй мэдээлэл нь нийт ирүүлсэн мэдээллийн 50-д хүрэхгүй бол уг төслийг үнэлэхээс татгалзаж энэ тухай эргэн мэдэгдэх эсхүл шаардлагатай тохиолдолд санал ирүүлэгчээс нэмэлт тодруулга авах, зөрүүтэй болон ойлгомжгүй мэдээллийг засуулах зэрэг ажлуудыг гүйцэтгэнэ. 4) Төслүүдийн "Урьдчилсан үнэлгээ"-г аргачлалын Хавсралт 6-т заасан маягтын дагуу хийнэ. Энэхүү үнэлгээнээс төслийг а. иж бүрэн үнэлгээ хийх шаардлагагүй, нэн тэргүүнд хэрэгжүүлэх б. иж бүрэн үнэлгээ хийх шаардлагагүй, хасах в. иж бүрэн үнэлгээний шатанд шилжүүлэх гэсэн 3 ангилалд хуваан аргачлалын Хавсралт 7-т заасан маягтын дагуу нэгдсэн дүгнэлт гарган, баталгаажуулна. 5) "Урьдчилсан үнэлгээ"-ны шатнаас иж бүрэн үнэлгээний шатанд шилжүүлэхээр шийдвэрлэсэн төслүүдэд энэхүү аргачлалын Тав дахь хэсэгт заасны дагуу "Иж бүрэн үнэлгээ" хийнэ. 6) Урьдчилсан болон иж бүрэн үнэлгээний шатны үр дүнд үндэслэн аргачлалын дагуу төслийг эрэмбэлнэ. 7) Төслийн эрэмбийн үр дүнд үндэслэн аргачлалд заагдсаны дагуу УХОХ-т тусгах төслийн сонголтыг хийн заасан маягтын дагуу нэгдсэн тайлан гарган, баталгаажуулна.

Хүснэгт 3.1. Үнэлгээний үе шат

Үнэлгээ хийх байгууллага	Үнэлгээний үе шат	Үнэлгээний маягт
Төсвийн ерөнхийлөн захирагчдын өөрийн үнэлгээ	1) Урьдчилсан үнэлгээ: Урьдчилсан үнэлгээний хуудасны дагуу УХОХ-т тусгах төслийг сонгоно. 2) Төслийн саналын маягтад шаардлагатай мэдээлэл бүрэн бөглөгдсөн эсэхийг нягтлах 3) Төслийн саналын маягт дахь мэдээллийн иж бүрэн	1. Урьдчилсан үнэлгээний хуудас 2. ТЭЗ-ийн иж бүрэн үнэлгээний хуудас

	<p>байдлыг нягтлах (Мэдээлэл хангалтгүй тохиолдолд мэдээлэл нөхөж оруулах)</p> <p>4) Төслүүдийн урьдчилсан үнэлгээг заасан маягтын дагуу хийж гүйцэтгэнэ.</p> <p>5) Төслийн иж бүрэн үнэлгээг аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ. Төслийн иж бүрэн үнэлгээний оноонд үндэслэн А, В, С үнэлгээ өгнө. (Төслийн иж бүрэн үнэлгээний хуудас)</p> <p>6) УХОХ-т тусгах төслийн иж бүрэн үнэлгээ, эрэмбийн нэгдсэн дүгнэлт гаргана.</p>	<p>3. Төслийн иж бүрэн үнэлгээ, эрэмбийн нэгдсэн дүгнэлт</p>
<p>Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бие даасан үнэлгээ, төслийг эрэмбэлэх, сонгох</p>	<p>1) ТЕЗ-аас ирүүлсэн төслийн саналын маягт дахь материалын иж бүрдлийг нягтлан, нөхөн бүрдүүлэлт хийнэ. (Төслийн материалын бүрдлийг шалгах хуудас)</p> <p>2) Төслийн саналын маягтууд холбогдох аргачлалын дагуу бүрэн бөглөгдсөн эсэхийг нягтална. Маягтууд дахь хариултын тоо нийт асуултын 50 хувьд хүрэхгүй байвал үнэлгээ хийхээс татгалзаж энэ тухай эргэн мэдэгдэх эсхүл гүйцээн ирүүлэхийг хүснэ.</p> <p>3) Төслийн саналын маягтуудыг нэг бүрчлэн нягтлан бүрэн хариулсан эсэх, мэдээллийн зөрүүтэй эсэх, хангалттай мэдээлэл өгөхүйц эсэхийг тодорхойлон нийт ирүүлсэн мэдээллийн 50 хувьд хүрэхгүй бол үнэлгээ хийхээс татгалзаж энэ тухай эргэн мэдэгдэх эсхүл гүйцээн ирүүлэхийг хүснэ.</p> <p>4) Төслүүдийн урьдчилсан үнэлгээг заасан маягтын дагуу хийж гүйцэтгэнэ.</p> <p>5) Төслийн иж бүрэн үнэлгээг аргачлалын дагуу хийж гүйцэтгэнэ. Төслийн иж бүрэн үнэлгээний оноонд үндэслэн А, В, С үнэлгээ өгнө. (Төслийн иж бүрэн үнэлгээний хуудас)</p> <p>6) Урьдчилсан болон иж бүрэн үнэлгээний дүнд үндэслэн төслийг эрэмбэлэх, сонгох (хариуцсан бүтцийн нэгжийн албан хаагч), сонгож эрэмбэлсэн төслүүдийг нэгтгэх</p> <p>7) Төслийн эрэмбийн дагуу УХОХ-т тусгах төслүүдийн сонголтыг хийн, шаардлагатай тохиолдолд талуудтай зөвшилцөн, эцсийн үнэлгээний дүнг баталгаажуулна. (үнэлгээний дүгнэлт)</p>	<p>1. Урьдчилсан үнэлгээний хуудас</p> <p>2. ТЕЗ-ийн иж бүрэн үнэлгээний хуудас</p> <p>3. Төслийн иж бүрэн үнэлгээ, эрэмбийн нэгдсэн дүгнэлт</p>

*Хаалтанд ашиглах маягтыг дурдав.

3.2 Төслийн урьдчилсан үнэлгээ

Төслийн үнэлгээний эхний шатанд төслийн Урьдчилсан үнэлгээг хийнэ. Урьдчилсан үнэлгээ нь нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай буюу иж бүрэн үнэлгээ хийх шаардлагагүй УХОХ-т тусгах, эсхүл иж бүрэн үнэлгээ хийлгүйгээр хасагдах төслийг урьдчилан тодорхойлох зорилготой.

ТЕЗ санал тавих төсөл тус бүр дээр УХОХ-ийн төсөл боловсруулах зааварчилгаанд заагдсаны дагуу Хавсралт 6-д заасан маягт дахь Урьдчилсан үнэлгээний хуудсанд дурдсан асуулгад үнэн зөв хариулж, дүгнэлт тайлбарыг гарган, санал авах маягтын багцын хамт хүргүүлсэн байна. Энэхүү хуудас дээр тулгуурлан Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага давхар нягтлан, Урьдчилсан үнэлгээний нэгдсэн дүгнэлтийг гаргана.

Урьдчилсан үнэлгээний дүгнэлтээр а. Иж бүрэн үнэлгээ хийх шаардлагагүй, нэн тэргүүнд хэрэгжүүлэх, б. Иж бүрэн үнэлгээ хийх шаардлагагүй, хасах, в. Иж бүрэн үнэлгээнд шилжүүлэх гэсэн ангилалд хуваан, дээрх "УХОХ-т тусгах төслийн санал бэлтгэх

зааварчилгаа"-ны Хавсралт 7-д заасан нэгдсэн дүгнэлтийг гарган баталгаажуулна. Үүнд, Төсвийн тухай хуулийн 28.7.1, 28.7.2-т заагдсан үндэсний аюулгүй байдал, улсын батлан хамгаалах үйл ажиллагаанд чиглэсэн, эсхүл байгалийн гамшгийн үр дагаврыг арилгах, нөхөн сэргээхэд чиглэсэн нэн тэргүүнд яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг иж бүрэн үнэлгээ хийлгүй төслийн үнэлгээний эцсийн шатны эрэмбэд нэгдүгээрт эрэмбэлнэ. Харин үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах үйл ажиллагаатай зөрчилдөх, олон улсын гэрээ болон холбогдох заалт эсхүл олон улсын гэрээнд заагдсан аливаа үүрэгтэй зөрчилдөх, төслийн үйл ажиллагаанаас үүдэн хүрээлэн буй орчинд ноцтой хор хөнөөл учруулж болзошгүй төсөл арга хэмжээг иж бүрэн үнэлгээ хийх шаардлагагүйд тооцон төслийн хагсаалтаас хасна.

3.3 Төслийн иж бүрэн үнэлгээ

Төсвийн ерөнхийлөн захирагчид аргачлалын дагуу урьдчилсан үнэлгээ хийж, төслийн саналыг боловсруулсны дараа төслийн саналын маягт дахь мэдээлэлд үндэслэн оноо өгч, хувийг тооцон үнэлгээ өгсний дараа Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад төслийн саналаа хүргүүлнэ.

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгах төслийг үнэлэхдээ төслийн "Ач холбогдол" болон "Хэрэгжих боломж" хоёрыг ерөнхий шалгуур үзүүлэлт болгож, тус бүрийнх нь үндсэн шалгуур үзүүлэлтээр оноо өгнө. Үндсэн шалгуур үзүүлэлтийг Төсвийн тухай хуулийн 28.3 дугаар зүйлд заасны дагуу тогтоосон бөгөөд 3.4, 3.5-д дурдах дэд шалгуур үзүүлэлтийг жишиг үзүүлэлтийн дагуу оноо өгч үнэлнэ.

3.4 Ерөнхий шалгуур үзүүлэлт 1: Ач холбогдол

Ач холбогдол тодорхойлох үндсэн шалгуур үзүүлэлт нь доорх хүснэгтэд үзүүлснээр 6 хэсэгт хуваагдаж, тус бүрийн оноотой байна. Нийтлэг хэсгийн хувьд дээд оноо нь 49.5 байх ба Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үнэлгээнд хэрэглэгдэх үндсэн шалгуур үзүүлэлтийн (төслийг эрэмбэлэх үнэлгээний матриц) оноотой нийлээд дээд оноо нь 70.5 болно. Улсын хөрөнгө оруулалтын төсөл нь үндэсний хөгжлийн бодлогын зорилтыг хангахад хувь нэмэр оруулна гэдэг үүднээс хөгжлийн бодлогын зорилттой нийцсэн байдалын оноо нь хамгийн өндөр оноотой байна.

Үндсэн шалгуур үзүүлэлт		Оноо		Тодорхойлолт/тайлбар
		Нийтлэг	Зөвхөн ҮХГ	
1.1	Хөгжлийн бодлогын зорилго, зорилттой нийцэх байдал	12 оноо	6 оноо	Төсөл, арга хэмжээ болон холбогдох үйл ажиллагаа нь Засгийн газраас баталсан хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд туссан зорилтыг хангахад хувь нэмэр оруулах гэдэг үүднээс урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилттой уялдах байдлыг үнэлнэ.
1.2	Бусад төсөл, арга хэмжээтэй уялдах байдал	4.5 оноо	3 оноо	Тухайн төсөл бусад төслийн урьдач нөхцөл болох, төслийн үр дүн өөр төсөлд нөлөөлөх гэх мэт уялдаа холбоо байгаа эсэхийг үнэлнэ.
1.3	Нийгмийн ач холбогдол	9 оноо	3 оноо	Төслөөс үүсэн гарах нийгмийн ач холбогдлын цар хүрээг харгалзан хөрөнгө оруулалт өгөөжтэй эсэхийг үнэлнэ (Зардал үр ашгийн тооцоо орно).
1.4	Эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж	9 оноо	3 оноо	Төслөөс үүсэн гарах эдийн засгийн үр ашгийн цар хүрээнд үндэслэн, үндэсний эдийн засгийн хөгжлийн үүднээс хөрөнгө оруулалтын өгөөжтэй эсэхийг үнэлнэ.
1.5	Хүрээлэн буй орчинд	6 оноо	3 оноо	Хүрээлэн буй орчинд болон хүрээлэн буй

	үзүүлэх нөлөө			орчныг хамгаалах арга хэмжээнд эерэг нөлөөтэй эсэхийг үнэлнэ.
1.6	Бүс, орон нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө	9 оноо	3 оноо	Бүс, орон нутгийн хөгжлийн боломж, хэрэгцээнд нийцэж байгаа эсэхийг үнэлнэ.

3.4.1 Үндсэн шалгуур үзүүлэлт 1: Хөгжлийн бодлогын зорилго, зорилттой нийцэх байдал

Тодорхойлолт: Төсөл, арга хэмжээ нь төрөөс баталсан хөгжлийн бодлогын баримт бичигтэй нийцэж, тэдгээрт туссан зорилтыг хангахад хувь нэмэр оруулах гэдэг үүднээс урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан зорилго, зорилтыг хангахад нөлөөлөх байдлыг үнэлнэ. Уг үндсэн шалгуур үзүүлэлт нь тус бүр 3 оноотой 5 дэд шалгуур үзүүлэлтээс бүрдэнэ.

Үнэлэх арга: Дэд шалгуур үзүүлэлт бүрийг 0-3 оноотой 4 үе шатаар үнэлнэ. Доорх хүснэгт дэх үзүүлэлтийн дагуу оноо өгч үнэлнэ.

Дэд шалгуур үзүүлэлт	Оноо	Жин	Жишиг үзүүлэлт	Үнэлэх арга, анхаарах зүйл
1.1.1 Урт хугацааны хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал	3	1	3: Тухайн төсөл, арга хэмжээ нь бодлогын баримт бичигт дурдагдсан тодорхой зорилго, зорилттой нийцнэ. 2: Тухайн төсөл, арга хэмжээ нь бодлогын зорилго, зорилттой агуулгын хувьд нийцнэ. 1: Тодорхой зорилго, зорилттой нийцэхгүй боловч тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх яаралтай эсхүл зайлшгүй шаардлага үүссэн. 0: Урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдахгүй.	"Алсын хараа 2050" улсын хөгжлийн урт хугацааны бодлогын зорилго, зорилтыг хангахад нөлөөлөх төсөл эсэх, бодлогын баримт бичигт төслийн хэрэгцээ, шаардлагын талаар дурдагдсан эсэхийг нягтална. Урт хугацааны бодлогын тодорхой зорилгыг хангах бол 3 оноо. Урт хугацааны бодлогын зорилго, зорилготой ижил төстэй зорилгыг хангах бол 2 оноо. Урт хугацааны бодлогын чиглэлд хамаарах бөгөөд уг бодлогын тодорхой зорилготой нийцэхгүй боловч зорилтыг хангахын тулд хэрэгжүүлэх яаралтай эсхүл зайлшгүй шаардлага үүссэн бол 1 оноо. Урт хугацааны бодлогын чиглэлд ороогүй, зорилготой хамааралгүй бол 0 оноо.

1.1.2. 10 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал	3	1	<p>3: Тухайн төсөл, арга хэмжээ нь 10 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын тодорхой зорилго, зорилттой нийцнэ.</p> <p>2: Тухайн төсөл, арга хэмжээ нь 10 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилттой агуулгын хувьд нийцнэ.</p> <p>1: Тодорхой зорилго, зорилттой нийцэхгүй боловч тухайн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх яаралтай эсхүл зайлшгүй шаардлага үүссэн.</p> <p>0: 10 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдахгүй.</p>	<p>"Хөгжлийн зорилтот хөтөлбөр" зэрэг 10 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хангахад нөлөөлөх эсэхийг нягтална.</p> <p>10 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хангахад нөлөөлөх бол 3 оноо.</p> <p>10 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний агуулгатай нийцэх бол 2 оноо.</p> <p>10 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилттой нийцэхгүй боловч тухайн төслийг хэрэгжүүлэх яаралтай эсхүл зайлшгүй шаардлага үүссэн бол 1 оноо.</p> <p>10 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилтод хамаарахгүй, бол 0 оноо.</p>
1.1.3. 5 хүртэлх жилийн хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал	3	1	<p>Тухайн төсөл, арга хэмжээ нь 5 хүртэлх жилийн хөгжлийн бодлогын тодорхой зорилго, зорилттой нийцнэ.</p> <p>2: Тухайн төсөл, арга хэмжээ нь 5 хүртэлх жилийн хөгжлийн бодлогын зорилго, зорилттой агуулгын хувьд нийцнэ.</p> <p>1: Тодорхой зорилго, зорилттой нийцэхгүй боловч тухайн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх яаралтай эсхүл зайлшгүй шаардлага үүссэн.</p> <p>0: 5 хүртэлх жилийн хөгжлийн бодлоготой уялдахгүй.</p>	<p>"Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг 5 хүртэлх жилийн хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хангахад нөлөөлөх төсөл эсэхийг нягтална.</p> <p>5 хүртэлх жилийн хөгжлийн бодлогын тодорхой зорилго, зорилтыг хангах бол 3 оноо.</p> <p>5 хүртэлх жилийн хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хангахад агуулгын хувьд нийцэж буй бол 2 оноо.</p> <p>5 хүртэлх жилийн дунд хугацааны хөгжлийн бодлогын зорилго, зорилттой нийцэхгүй боловч тухайн төслийг хэрэгжүүлэх яаралтай эсхүл зайлшгүй шаардлага үүссэн бол 1 оноо.</p> <p>5 хүртэлх жилийн хөгжлийн бодлоготой уялдахгүй бол 0 оноо.</p>
1.1.4. Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын зорилттой нийцэх байдал	3	1	<p>Тухайн төсөл, арга хэмжээ нь бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын тодорхой зорилго, зорилттой нийцнэ.</p> <p>2: Тухайн төсөл, арга хэмжээ нь бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын зорилго, зорилттой агуулгын хувьд нийцнэ.</p> <p>1: Тодорхой зорилго, зорилттой</p>	<p>"Бүсийн хөгжлийн зорилтот хөтөлбөр", "Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл", "Аймаг, Нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" зэрэг дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг дэх бүс, орон нутгийн</p>

			<p>нийцэхгүй боловч тухайн төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх яаралтай эсхүл зайлшгүй шаардлага үүссэн.</p> <p>0: Бүс, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдахгүй.</p>	<p>хөгжлийн хөтөлбөрийн зорилго, зорилт, үйл ажиллагаатай нийцэж буй эсэх, бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын зорилго, зорилтыг хангахад нөлөөлөх эсэхийг нягтална.</p> <p>Дээр дурдсан бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын зорилтыг хангах зорилго бүхий төсөл бол 3 оноо.</p> <p>Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогын зорилтыг хангахын тулд хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбоотой бол 2 оноо.</p> <p>Бүс, орон нутгийн хөгжлийн бодлогод тусгагдсан зорилго, зорилттой нийцэхгүй боловч тус төслийг хэрэгжүүлэх яаралтай эсхүл зайлшгүй шаардлага үүссэн бол 1 оноо.</p> <p>Бүс, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдахгүй бол 0 оноо.</p>
--	--	--	--	---

3.4.2 Үндсэн шалгуур үзүүлэлт 2: “Бусад төсөл, арга хэмжээтэй уялдах байдал”

Тодорхойлолт: Тухайн төсөл өөр бусад төслийн урьдач нөхцөл болох, төслийн үр дүн бусад төсөлд нөлөөлөх гэх мэт уялдаа холбоо байгаа эсэхийг үнэлнэ. Үйл ажиллагаа нь тус тусдаа бие даан хэрэгжих боловч нийтлэг нэг зорилготой бол тэдгээр төслүүдийг багц төсөл гэнэ. хэд хэдэн төслөөс бүрдэн, төсөл тус бүрийн үр дүн нь нийлээд нэг үр дүнд хүрэх төслүүдийг нийлмэл цогц төсөл гэнэ.

Үнэлэх арга: 0-3 оноотой, 4 үе шатаар үнэлнэ. Доорх хүснэгт эд байгаачлан, жишиг дэх үзүүлэлтийн дагуу оноо өгч, үнэлнэ. УХОХ-т туссан бусад төсөл, арга хэмжээтэй уялдах байдлыг чухалчлан авч үзэх үүднээс хөтөлбөрт “туссан” болон “тусаагүй” төсөл гэж дэд шалгуур үзүүлэлтэд хуваасны дагуу 1.2.2-т дурдсан жин нь 0.5 болон багассан болно.

Дэд шалгуур үзүүлэлт	Оноо	Жин	Жишиг үзүүлэлт	Үнэлэх арга, анхаарах зүйл
1.2.1 УХОХ-т туссан бусад төсөл, арга хэмжээтэй уялдах байдал	3	1	<p>3: УХОХ-т туссан нэг ба хэд хэдэн томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх урьдач нөхцөл болсон, бусад төслийн үр дүнд шууд нөлөөлөх төсөл</p> <p>2: УХОХ-т туссан ямар нэг багц төслийн бүрэлдэхүүн хэсэг болсон төсөл</p> <p>1: УХОХ-т туссан нэг ба хэд хэдэн томоохон төсөл, арга хэмжээг нэгтгэсэн, бүрэлдэхүүн төслөөс хамааран хэрэгжих нийлмэл цогц төсөл</p> <p>0: Дээрх тохиолдлуудын аль нь ч биш.</p>	<p>Бусад төслийн урьдач нөхцөл болох, тухайн төсөл хэрэгжих эсэх нь бусад төслийн хэрэгжилт болон үр дүнд нөлөөлөх бол 3 оноо өгнө.</p> <p>Тухайлбал, аймгийн төвийн цахилгаан станцын хүчин чадлыг нэмэгдүүлэх төсөл нь махны үйлдвэрийн төсөлтэй их хамааралтай. Эрчим хүчний хангамж хүрэлцээгүй бол махны үйлдвэр төлөвлөсөн хүчин чадлаараа ажиллаж чадахгүй учраас цахилгаан станцын төсөл нь тэргүүлэх төсөл (урьдач нөхцөл) болно.</p> <p>Тухайн төсөл багц төслийн нэг бүрэлдэхүүн бол 2 оноо.</p> <p>Тухайлбал, авто замын 2 төсөл, төмөр замын 2 төсөл, логикийн 2 төсөл, цэвэр ус хангамжийн 1</p>

				<p>төсөл нь "Таван толгойн нүүрсний уурхай"-н үр ашгийг нэмэгдүүлэхээр хэрэгжих бол тэдгээр төслүүдийг багц болгон, төсөл тус бүр 2 оноо байна. Нийлмэл цогц төсөл бол 1 оноо өгнө.</p> <p>Тухайлбал, "Эмээлтийн хөнгөн аж үйлдвэрийн паркийн төсөл" нь авто замын 2 төсөл, цэвэр усны 2 төсөл, ариутгах татуургын 1 төсөл, аж үйлдвэрийн 2 төслөөс бүрдсэн нийлмэл төсөл юм.</p> <p>Бусад төслийн үр дүнд шууд нөлөөлөхгүй (бусад төслийн үр дүнг ашиглах, төслийн үр дүнд харилцан нөлөөлөхгүй) төсөл бол 0 оноо байна.</p> <p>Тухайлбал, "Авто замын дагуу түр буудаллах, үйлчилгээний цогцолбор байгуулах төсөл" нь бие даан хэрэгжих боломжтой ба шаардлагатай дэд бүтэц болон арга хэмжээ нь бусад төслөөс үл хамааран хэрэгжинэ.</p>
1.2.2. УХОХ-т тусаагүй төсөл, арга хэмжээтэй уялдах байдал	3	0.5	<p>3: УХОХ-т туссанаас бусад нэг ба хэд хэдэн томоохон төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх урьдач нөхцөл болсон, бусад төслийн үр дүнд шууд нөлөөлөх төсөл</p> <p>2: УХОХ-т туссанаас бусад ямар нэг багц төслийн бүрэлдэхүүн хэсэг болсон төсөл</p> <p>1: УХОХ-т туссанаас бусад нэг ба хэд хэдэн томоохон төсөл, арга хэмжээг нэгтгэсэн, бүрэлдэхүүн төслөөс хамааран хэрэгжих нийлмэл цогц төсөл</p> <p>0: Дээрх тохиолдлуудын аль нь ч биш.</p>	<p>Үнэлэх арга нь 2-1-той адил бөгөөд УХОХ-т тусаагүй төсөл бол үүнд хамаарна.</p>

3.4.3 Үндсэн шалгуур үзүүлэлт 3: "Нийгмийн ач холбогдол"

Тодорхойлолт: Төслийн нийгмийн үр өгөөжийн цар хүрээг үнэлнэ. Төрийн үйлчилгээг сайжруулах, эрүүл мэнд, урт наслалт, иргэдийн мэдлэг, боловсролын түвшнийг дээшлүүлэх, эрүүл ба аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэх, үндэсний үнэт зүйлийг хадгалах, хамгаалах, бий болгох, нийгмийн ач холбогдлын үзүүлэлт нь салбарын стандарт түвшнийг хангах эсэх гэсэн зургаан өнцгөөс үнэлнэ.

Үнэлэх арга: 1.3.1-ээс 1.3.6 хүртэлх дэд шалгуур үзүүлэлт нь 3, 2, 1 гэсэн 3 үе шаттайгаар үр ашгийн түвшинд үндэслэн оноо өгч, нийгмийн үр ашиг байхгүй тохиолдолд 0 оноо байна. Нийт 18 оноотой байх ба дээд оноог 9 болгон хөрвүүлэх замаар оноог тооцоолно. Жишээлбэл: 1.3.1 нь 2 оноо, 1.3.2 нь 3 оноо, 1.3.3 нь 2 оноо, 1.3.4 нь 2 оноо, 1.3.5 нь 0 оноо 1.3.6 нь 1 оноо байвал $(2+3+2+2+0+1) \times 9/18 = 5$ болон 9 онооноос 5 оноо авсан байна.

Дэд шалгуур үзүүлэлт	Оноо (9 дээд оноо)	Жин	Жишиг үзүүлэлт	Үнэлэх арга, анхаарах зүйл
1.3.1. Төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээний стандартыг сайжруулахад үзүүлэх нөлөө	3	1/2	3: Шууд, хүчтэй нөлөөтэй 2: Шууд нөлөөтэй 1: Шууд бус нөлөөтэй	Төслийн нийгмийн дэд бүтцийн үйлчилгээний чанарыг сайжруулахад үзүүлэх нөлөөг үнэлнэ. Дэд бүтцийн барилга, байгууламж бий болон иргэдийн амьдралын ая тухтай байдлыг сайжруулах тохиолдолд 3 оноо байна. Төрөөс олон нийтэд үзүүлэх үйлчилгээний стандартыг сайжруулахад шууд бус нөлөөтэй. Тухайлбал эмнэлэг, цахилгаан станц барих, ус, ариутгах татуургын хангамж гэх мэт. Одоо байгаа дэд бүтцийг шинэчлэх, сайжруулах замаар иргэдийн амьдралын ая тухтай байдлыг дээшлүүлэх тохиолдолд 2 оноо байна. Тухайлбал, эмнэлгийн барилга байгууламж, тоног төхөөрөмжийн шинэчлэл, ус, ариутгах татуургын дэд бүтцийг сайжруулах гэх мэт. Дэд бүтэц байгуулах болон шинэчлэх ажил биш боловч ирээдүйд дэд бүтцийн үйлчилгээний стандартыг сайжруулахад холбогдох төсөл бол 1 оноо байна. Тухайлбал, боловсролын шинэчлэлийн төсөл гэх мэт.
1.3.2. Хүний эрүүл, урт удаан амьдрахад үзүүлэх нөлөө	3	1/2	3: Шууд, хүчтэй нөлөөтэй 2: Шууд нөлөөтэй 1: Шууд бус нөлөөтэй	Бие махбодын болон сэтгэцийн эрүүл мэнд, насжилтыг уртасгахад үзүүлэх нөлөөллийг үнэлнэ. Тухайлбал, эмнэлгийн барилга байгууламж 3 оноо, шахмал түлшний үйлдвэр 2 оноо, спортын төвийн шинэчлэл 1 оноо, хүнсний аюулгүй байдлыг хангах зорилго бүхий махны үйлдвэр, хорио цээрийн бүсийн цогцолборын барилгын технологийг сайжруулах нийлмэл цогц төсөл 0 оноо гэх мэт.
1.3-3. Иргэдийн мэдлэг, боловсролын түвшнийг дээшлүүлэхэд үзүүлэх нөлөө	3	1/2	3: Шууд, хүчтэй нөлөөтэй 2: Шууд нөлөөтэй 1: Шууд бус нөлөөтэй	Бичиг үсгийн тайлагдалт болон бүх шатны боловсролын байгууллагын элсэлтийн хувь, мэдлэг, бүтээлч байдал, бүтээлч сэтгэлгээний түвшнийг дээшлүүлэхэд үзүүлэх нөлөөг үнэлнэ. Тухайлбал, сургууль, цэцэрлэгийн барилгын төсөл 3, их дээд сургуулийн хувьд 2 оноо байна.
1.3.4. Иргэдийн эрүүл, аюулгүй, зохистой орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд үзүүлэх нөлөө	3	1/2	3: Шууд, хүчтэй нөлөөтэй 2: Шууд нөлөөтэй 1: Шууд бус нөлөөтэй	Дэд бүтцийн хэрэглээ, хангамж нэмэгдэх, гэмт хэрэг буурах, эрүүл мэндийн баталгаат байдал, олон нийтийн аюулгүй байдал, тав тухтай амьдрах орчинд үзүүлэх нөлөөг үнэлнэ. Жишээлбэл: Зам, инженерийн байгууламж, хяналтын камер суурилуулах зэрэг төсөл 3 оноо, Улаанбаатар хотод хямд үнэтэй орон сууц барих төсөл 3 оноо, Хариуцлагыг сайжруулах төсөл 1 оноо, Төсвийн үр

				ашгийг дээшлүүлэх төсөл 1 оноо гэх мэт.
1.3.5. Үндэсний үнэт зүйлийн хадгалах, хамгаалах, бий болгоход үзүүлэх нөлөө	3	1/2	3: Шууд хүчтэй нөлөөтэй 2: Шууд нөлөөтэй 1: Шууд бус нөлөөтэй	Үндэсний үнэт зүйл, түүх, урлаг, соёл, зан заншил, уламжлал, биет болон биет бус соёлын өвийг хадгалах, хамгаалах, бий болгох, хөгжүүлэх, түгээхэд үзүүлэх нөлөөг үнэлнэ. Жишээлбэл: Музей, соёл урлагийн байгууламж барих төсөл 3 оноо, түүхэн дурсгалт цогцолбор байгуулах төсөл 2 оноо гэх мэт.
1.3.6.Зардал үр ашгийн тооцоонд дурдагдсан нийгмийн ач холбогдлын үзүүлэлт нь тухайн салбарын стандарт түвшнийг хангах эсэх	3	1/2	3: Эдийн засгийн өгөөжийн дотоод хувь (ЭЗӨДХ) нь стандарт түвшнээс дээш ба тодорхой хэмжээний эрсдэл (нийгмийн үр ашиг ба зардлын өөрчлөлт) даах чадвартай 2: ЭЗӨДХ нь стандарт түвшнээс дээш боловч нийгмийн үр ашиг ба зардлын өөрчлөлтийг даах чадваргүй. 1:ЭЗӨДХ-ийг тооцоогүй боловч нийгмийн үр ашгийг тодорхой дурдсан. 0: Нийгмийн ач холбогдол нь тодорхойгүй.	ЭЗӨДХ нь стандарт түвшнийг (нийгмийн хорогдуулалтын хувь) хангаж буй эсэхийг үнэлнэ. ЭЗӨДХ нь Монгол улсын стандарт хөрвүүлгийн фактороос (эсхүл АХБ-ны 9%) дээш бөгөөд мэдрэмжийн шинжилгээгээр тодорхой хэмжээний эрсдэлийг (зардал 10% өсөх, үр ашиг 10% орчим буурах) даах чадвартай бол 3 оноо. ЭЗӨДХ нь Монгол Улсын стандарт хөрвүүлгийн фактороос (эсхүл АХБ-ны 9%) дээш боловч мэдрэмжийн шинжилгээгээр зардал, үр ашгийн өөрчлөлтөөс шалтгаалан (зардал 10% өсөх, үр ашиг 10% орчим буурах) буурахаар бол 2 оноо. ЭЗӨДХ нь Монгол Улсын стандарт хөрвүүлгийн фактороос (эсхүл АХБ-ны 9%) доогуур эсхүл тооцоо хийгээгүй боловч эдийн засгийн үр ашгийг тодорхой дурдсан бол 1 оноо. Нийгмийн ач холбогдлыг тодорхойлоогүй бол 0 оноо. ЗҮАТ-г хийхдээ дараах үр ашгийг тооцон оруулж болно. Доорх үзүүлэлтүүдэд шууд нөлөө үзүүлэх тохиолдолд 3 оноо байна. Боловсролын шинэчлэл, амнапгийн байгууламж зэрэг. Боловсролын салбарын хувьд: • Орлого нэмэгдүүлэх • Сургалтын зардлыг бууруулах Эрүүл мэндийн салбарын хувьд: • Өвчлөлтийн давтамж буурснаар эрүүл мэндийн зардал буурах • Тав тухтай байдал сайжрах (хүрэлцээ нэмэгдэх, хүлээх цаг багасах) • Эрүүл мэндийн үйлчилгээ сайжрах (өвчтөний тоо ба үйлчилгээний чанар зэргийг тооцоолох боломжтой тохиолдолд)

3.4.4 Үндсэн шалгуур үзүүлэлт 4: “Эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж”

Тодорхойлолт: Төслийн үр дүнд бий болох эдийн засгийн үр ашгийн цар хүрээнд үндэслэн, үндэсний эдийн засгийн хөгжлийн үүднээс хөрөнгө оруулалтын өгөөжийг үнэлнэ. Үйлдвэрлэл, үйлчилгээний өсөлт, экспорт импорт, ажлын байр, иргэдийн цалин, бодит орлогыг нэмэгдүүлэхэд үзүүлэх үр нөлөө зэрэг шууд бус нөлөө ба төслийн ашиг хүртэгчдэд үзүүлэх шууд нөлөөний өнцгөөс авч үзэн (дэд шалгуур үзүүлэлт) оноо өгснөөр иж бүрэн үнэлгээг хийнэ.

Үнэлэх арга: 1.4.1-ээс 1.4.6-д дурдсан дэд шалгуур үзүүлэлт нь 3, 2, 1 гэсэн 3 үе шаттай үр нөлөөний түвшинд үндэслэн оноо өгнө. Эдийн засгийн үр нөлөөгүй бол 1.4.7-д хамаарах бөгөөд 0 оноотой байна. Нийт 18 оноотой байх ба дээд оноог 9 болгон хөрвүүлэх замаар оноог тооцоолно.

Дэд шалгуур үзүүлэлт	Оноо (дээд оноо)	Жин	Жишиг үзүүлэлт	Үнэлэх арга, анхаарах зүйл
1.4.1. Үндэсний үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэхэд үзүүлэх нөлөө	3	1/2	3: Шууд, хүчтэй, чухал нөлөөтэй 2: Шууд нөлөөтэй 1: Шууд бус нөлөөтэй	Иргэдийн эрэлт, хэрэгцээг хангах, хүрэлцээ муутай бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, хөгжүүлэхэд үзүүлэх үр нөлөөг үнэлнэ. Үнийн дүн болон тоо хэмжээгээр үнэлэх ба үйлдвэрлэл, үйлчилгээг шууд нэмэгдүүлэх бол 3 оноо. Үйлдвэрлэл, үйлчилгээ нэмэгдэх боловч үр нөлөө нь хязгаарлагдмал (одоо байгаа дэд бүтцийн өргөтгөл гэх мэт) бол 2 оноо. Үйлдвэрлэл, үйлчилгээ шууд нэмэгдэхгүй боловч шууд бусаар холбогдох бол 1 оноо. Жишээлбэл: “Хүлэмжийн аж ахуй байгуулах төсөл” 3 оноо, “Цахилгаан станцын өргөтгөлийн төсөл” 2 оноо, “Авто замын өргөтгөлийн төсөл” 1 оноо гэх мэт.
1.4.2. Экспортыг дэмжих, импортыг орлоход үзүүлэх нөлөө	3	1/2	3: Шууд, хүчтэй, чухал нөлөөтэй 2: Шууд нөлөөтэй 1: Шууд бус нөлөөтэй	Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлоход үзүүлэх нөлөөг үнэлнэ. Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлоход шууд нөлөөтэй бол 3 оноо. Экспортыг нэмэгдүүлэх эсхүл импортыг орлох боловч үр нөлөө нь хязгаарлагдмал (одоо байгаа ажил үйлчилгээ, дэд бүтцийн өргөтгөл гэх мэт) бол 2 оноо. Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлоход шууд нөлөөлөхгүй боловч шууд бусаар холбогдох бол 1 оноо. Жишээлбэл: “Экспортыг дэмжих төсөл” 3 оноо, “Газрын тос боловсруулах үйлдвэрийн төсөл” 3 оноо, “Налайх аж үйлдвэрийн паркийн төсөл” 2 оноо, “Уул уурхайн дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих төсөл” 1 оноо байна.
1.4.3. Ажлын байр нэмэгдүүлэхэд үзүүлэх нөлөө	3	1/2	3: Шууд, хүчтэй, чухал нөлөөтэй 2: Шууд нөлөөтэй 1: Шууд бус нөлөөтэй	Төслийн бүтээн байгуулалтын болон ашиглалтын үе шатанд шууд ажлын байр бий болох бол 3 оноо. Шууд ажлын байр бий болох боловч ихэнх нь төслийн бүтээн байгуулалтын шатанд байх ба үр нөлөө нь

				<p>хязгаарлагдмал бол 2 оноо.</p> <p>Төсөл хэрэгжсэнээр шууд бусаар ажлын байр бий болох бол 1 оноо.</p> <p>Жишээлбэл: "Нийтийн тээврийг хөгжүүлэх төсөл" 3 оноо, "Уул уурхайг хөгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл" 3 оноо, "Ажлын байр нэмэгдүүлэхийг дэмжих төсөл" 2 оноо, "Орон сууцны дэд бүтэц хөгжүүлэх төсөл" 2 оноо, "Дээд боловсролын шинэчлэлийн төсөл" 1 оноо байна.</p>
1.4.4. Иргэдийн цалин, бодит орлогыг нэмэгдүүлэхэд үзүүлэх нөлөө	3	1/2	<p>3: Шууд, хүчтэй нөлөөтэй</p> <p>2: Шууд нөлөөтэй</p> <p>1: Шууд бус нөлөөтэй</p>	<p>Иргэдийн цалин болон бодит орлогыг нэмэгдүүлэхэд үзүүлэх үр нөлөөг үнэлнэ.</p> <p>Цалин, бодит орлого нэмэгдэх бол 3 оноо.</p> <p>Цалин, бодит орлого шууд нэмэгдэх боловч үр нөлөө нь хязгаарлагдмал (одоо байгаа ажил үйлчилгээ, дэд бүтцийн өргөтгөл гэх мэт) бол 2 оноо.</p> <p>Цалин, бодит орлого шууд нэмэгдэхгүй боловч шууд бусаар холбогдох бол 1 оноо.</p> <p>Жишээлбэл: "Алслагдсан орон нутагт сүүн бүтээгдэхүүнийг кластераар хөгжүүлэх зарчмаар үйлдвэрлэж, импортыг орлож, экспортыг нэмэгдүүлэх төсөл" 3 оноо, "Цагаан суваргын зэс молибден хайлуулах үйлдвэрийн төсөл" 3 оноо, "Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг өргөтгөх төсөл" 2 оноо, "Дээд боловсролыг дэмжих төсөл" 1 оноо, "Эрчим хүчний сүлжээний үр ашгийг дээшлүүлэх төсөл" 1 оноо байна.</p>
1.4.5. Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд үзүүлэх нөлөө	3	1/2	<p>3: Шууд, хүчтэй, чухал нөлөөтэй</p> <p>2: Шууд нөлөөтэй</p> <p>1: Шууд бус нөлөөтэй</p>	<p>Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд үзүүлэх нөлөөг үнэлнэ.</p> <p>Гадаадын шууд хөрөнгө оруулалт бодитоор нэмэгдэх бол 3 оноо.</p> <p>Гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжтой бол 2 оноо.</p> <p>Тухайн төслийн хувьд гадаадын шууд хөрөнгө оруулалт хийгдэхгүй ч шууд бусаар гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх боломжтой бол 1 оноо.</p> <p>Жишээлбэл: "Аялал жуулчлалын голлох чиглэлийн авто зам дагуу түр буудаллах, үйлчилгээний цогцолбор байгуулах төсөл" 2 оноо, "Багануур үйлдвэрлэл, технологийн паркийн дэд бүтцийг өргөтгөх төсөл" 1 оноо, "Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын 64мВт усан цахилгаан станц байгуулах төсөл" 1 оноо гэх мэт.</p>

<p>1.4.6. Зардал үр ашгийн тооцоо (ЗҮАТ)-нд дурдагдсан эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийн үзүүлэлт нь тухайн салбарын стандарт түвшнийг хангах эсэх</p>	3	1/2	<p>3: Эдийн засгийн өгөөжийн дотоод хувь (ЭЗӨДХ) нь стандарт түвшнээс дээш ба тодорхой хэмжээний эрсдэлийг (үр ашиг ба зардлын өөрчлөлт) даах чадвартай 2: ЭЗӨДХ нь стандарт түвшнээс дээш боловч эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж ба зардлын өөрчлөлтөөс шалтгаалан стандарт үзүүлэлтээс доогуур болох тохиолдол 1: ЭЗӨДХ-ийг тооцож гаргаагүй боловч нийгмийн үр ашгийг тодорхой тэмдэглэсэн</p>	<p>ЭЗӨДХ нь жишиг үзүүлэлтийг (нийгмийн хорогдуулалтын хувь) давж буй эсэхийг үнэлнэ. ЭЗӨДХ нь Монгол Улсын стандарт хөрвүүлгийн фактороос (эсхүл АХБ-ны 9%) дээш бөгөөд мэдрэмжийн шинжилгээгээр тодорхой хэмжээний эрсдэлийг (зардал 10% өсөх, үр ашиг 10% орчим буурах) даах бол 3 оноо. ЭЗӨДХ нь Монгол Улсын стандарт хөрвүүлгийн үзүүлэлтээс (эсхүл АХБ-ны 9%) дээш боловч мэдрэмжийн шинжилгээгээр зардал, үр ашгийн өөрчлөлтөөс шалтгаалан (зардал 10% өсөх, үр ашиг 10% орчим буурах) буурах тохиолдолд 2 оноо. ЭЗӨДХ нь Монгол Улсын стандарт хөрвүүлгийн үзүүлэлтээс (эсхүл АХБ-ны 9%) доогуур эсхүл тооцоо хийгээгүй боловч эдийн засгийн үр ашгийг тодорхой бичиж тэмдэглэсэн тохиолдолд 1 оноо байна.</p> <p>ЗҮАТ-г хийх үед тооцож гаргах эдийн засгийн үр ашиг нь тээврийн салбар бол тээврийн хэрэгслийн ашиглалтын зардал (VOC), аяллын цаг хугацааны зардал (TTC), хүлэмжийн хий багасгах гэх мэт зүйлс байна.</p>
---	---	-----	---	--

3.4.5 Үндсэн шалгуур үзүүлэлт 5: “Хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөө”

Тодорхойлолт: Хүрээлэн буй орчинд болон хүрээлэн буй орчныг хамгаалахад эерэг нөлөөтэй эсэхийг үнэлнэ.

Үнэлэх арга: 0-3 оноотой 4 үе шатаар үнэлнэ. Доорх хүснэгтэд дурдсан үзүүлэлтүүдийн дагуу оноо өгч үнэлнэ. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ (БОНБУ) болон түүнтэй ижил төстэй судалгааны үр дүнд үндэслэн үнэлгээг хийнэ. Хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэх нь тодорхой бол урьдчилсан үнэлгээний шатанд хасагдсан байх бөгөөд энэхүү шатанд хасагдаагүй төслийг үнэлнэ.

Дэд шалгуур үзүүлэлт	Оноо	Жин	Жишиг үзүүлэлт	Үнэлэх арга, анхаарах зүйл
<p>1.5.1. Хүрээлэн буй орчинд ээлтэй технологи, менежментийн шийдэлтэй эсэх</p>	3	1	<p>3: Тухайн төсөл, арга хэмжээ нь хүрээлэн буй орчинд ээлтэй технологи, менежментийн шийдэлтэй. (Жишээлбэл: ногоон технологи, эко дизайн, байгаль орчны менежментийн тогтолцоо гэх мэт) 2: Тухайн төсөл, арга хэмжээ нь технологийн алтернатив хувилбаруудыг тооцож үзсэн. Хэрэгжүүлэхгүй байх хувилбартай</p>	<p>Байгалийн нөөц газар, агаар, ус, хөрс, биологийн олон янз байдал, экосистемийн тэнцвэр, газрын бүтэц, бэлчээрийн байдал зэрэг хүрээлэн буй орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй технологи, шийдэлтэй эсэхийг үнэлнэ. Төсөл нь хүрээлэн буй орчны бохирдлын эсрэг авах арга хэмжээ, хог хаягдлыг боловсруулах/дахин боловсруулах, эрчим хүч хэмнэх, сэргээгдэх эрчим хүч зэрэгтэй холбоотой ногоон технологи, эдийн засгийн үр ашиг, хүрээлэн буй орчинд ээлтэй эко дизайн, байгаль орчны менежментийн тогтолцоог ашиглах бол 3 оноо. Дээрх дурдсантай адил технологи, арга хэрэгслийг ашиглахгүй ч Байгаль</p>

			харьцуулан хүрээлэн буй орчны нөлөөллийг тооцоолсон. 1: Хүрээлэн буй орчинд нөлөөгүй, уламжлалт технологи ашигласан. 0: Тодорхой дурдаагүй	орчинд ээлтэй технологи ашиглах, хүрээлэн буй орчинд нөлөөлөхөөр бол үйл ажиллагааны төлөвлөгөөгөө өөрчлөх зэрэг хувилбаруудыг авч үзсэн бол 2 оноо. Хүрээлэн буй орчинд нөлөөгүй, уламжлалт технологи ашиглаж буй бол 1 оноо. Хүрээлэн буй орчны нөлөөллийн талаар авч үзээгүй бол 0 оноо.
1.5.2.Хүрээлэн буй орчныг хамгаалах хариуцлагын тогтолцоог нэвтрүүлсэн эсэх	3	1	3: Олон талт оролцоог хангаж, эрх ашиг нь хөндөгдөж буй талуудтай хийсэн хэлэлцүүлэг, санал хураалтаар төсөл, арга хэмжээ дэмжигдсэн. 2: Олон талт оролцоог хангаж, эрх ашиг нь хөндөгдөж буй талуудын саналыг тодорхой хэмжээнд төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд тусгасан. 1 Төсөл арга хэмжээний мэдээллийг олон нийтэд ил болгосон. 0: Төсөл, арга хэмжээний мэдээлэл дутмаг, ил тод бус.	Төсөл, арга хэмжээний хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөний талаарх хариуцлага, мэдээллийн ил тод байдлыг хангасан байдлыг үнэлнэ. Олон талт оролцоо гэдэг нь мэргэжлийн холбоо, эрдэмтэн судлаачид, оршин суугч болон эрх ашиг нь хөндөгдөж буй талуудад хангалттай мэдээлэл хүргүүлсний дээр, уулзалт хэлэлцүүлэг удаа дараа хийн, тэдний саналыг авч, саналыг хэрхэн тусгасан талаар эргэн мэдээлэх үйл явц юм. Олон талт оролцоог хангах, эрх ашиг нь хөндөгдөж буй талуудтай ил тод харьцах, хариуцлага хүлээх нөхцөлийг бүрдүүлэх арга, механизмтай (олон нийтийн хэлэлцүүлэг, санал асуулга гэх мэт) бол 3 оноо. Олон талт оролцоог бүрэн хангаж, хэлэлцүүлэг хийгээгүй ч мэдээллийн ил тод байдлыг хангаж, олон нийтээс санал авах зэрэг арга хэмжээ авсан бол 2 оноо. Олон талт оролцоог хангаагүй ч, мэдээллийг олон нийтэд нээлттэй болгосон бол 1 оноо. Хүрээлэн буй орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдээлэл байхгүй бол 0 оноо.

3.4.6 Үндсэн шалгуур үзүүлэлт 6: “Бүс, орон нутгийн хөгжилд үзүүлэх нөлөө”

Тодорхойлолт: Төсөл хэрэгжих бүс, орон нутгийн хөгжлийн боломж, хэрэгцээ шаардлагад нийцэж байгаа эсэхийг үнэлнэ.

Үнэлэх арга: 0-3 оноотой 4 үе шатаар үнэлнэ. Доорх хүснэгтэд дурдсан үзүүлэлтийн дагуу оноо өгч үнэлнэ.

Дэд шалгуур үзүүлэлт	Оноо	Жин	Жишиг үзүүлэлт	Үнэлэх арга, анхаарах зүйл
1.6.1. Төсөл хэрэгжих бүс, орон нутгийн эдийн засгийн хэрэгцээ, шаардлагыг хангаж буй эсэх	3	1	3: Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалтыг ихээр нэмэгдүүлнэ. 2: Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ. 1: Бүс, орон нутгийн хөрөнгө оруулалтыг зохистой түвшинд хадгална. 0: Бүс, орон нутагт хөрөнгө оруулалтыг хязгаарлана.	Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын боловсруулах үзүүлэлтээр оноо өгнө.
1.6.2. Төсөл хэрэгжих бүс, орон нутгийн	3	1	3: Бүс, орон нутагт тухайн төсөл, арга хэмжээг нэн яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай.	Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын боловсруулах

нийгмийн хэрэгцээ, шаардлагыг хангаж буй эсэх			2: Бүс, орон нутагт тухайн төсөл, арга хэмжээг яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай. 1: Бүс, орон нутагт тухайн төсөл, арга хэмжээг заавал биш ч хэрэгжүүлэх шаардлагатай. 0: Бүс, орон нутагт тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагагүй.	үзүүлэлтээр оноо өгнө
1.6.3. Төсөл хэрэгжих бүс, орон нутгийн дэд бүтцийн хэрэгцээ, шаардлагыг хангаж буй эсэх	3	1	3: Бүс, орон нутагт тухайн төсөл, арга хэмжээг нэн яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай. 2: Бүс, орон нутагт тухайн төсөл, арга хэмжээг яаралтай хэрэгжүүлэх шаардлагатай. 1: Бүс, орон нутагт тухайн төсөл, арга хэмжээг заавал биш ч хэрэгжүүлэх шаардлагатай. 0: Бүс, орон нутагт тухайн төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагагүй.	Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын боловсруулах үзүүлэлтээр оноо өгнө

3.5 Ерөнхий шалгуур үзүүлэлт 2: “Хэрэгжих боломж”

Төслийн хэрэгжих боломжийн үнэлгээнд хүснэгтэд дурдсан 6 үндсэн шалгуур байна. Үндсэн шалгуур хоорондох онооны тэнцвэр нь “санхүүжилтийн эх үүсвэр, эдийн засгийн үр өгөөж”-ийг чухалчлан үзэж, хамгийн өндөр оноотой байхаар тогтоосон. Мөн төслийн бэлтгэл, төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжих үндэслэлийн оноог ч харьцангуй өндөр тогтоосон ба хэрэгжих боломжоор илүү төсөл нь өндөр оноогоор үнэлэгдэх болно.

	Үндсэн шалгуур үзүүлэлт	Оноо	Тодорхойлолт, тайлбар
2.1	Хууль, эрх зүйн орчин	3 оноо	Холбогдох хууль тогтоомжоор батлагдсан эрх зүйн үндэслэл, төрийн зүгээс үзүүлэх дэмжлэг байгаа эсэхийг үнэлнэ.
2.2	Дэд бүтцийн хүрэлцээ	3 оноо	Төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцээр хангагдсан эсэхийг үнэлнэ.
2.3	Төслийн бэлтгэл хангагдсан эсэх	9 оноо	Төслийн бэлтгэл хэр зэрэг хангагдсаныг үнэлнэ.
2.4	Төлөвлөлт, шийдлийн хувьд хэрэгжих боломжтой эсэх	9 оноо	Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө нь хэрэгжих үндэслэлтэй эсэхийг үнэлнэ.
2.5	Санхүү, эдийн засгийн хувьд хэрэгжих боломжтой эсэх	18 оноо	Төслийн санхүүжилтийн эх үүсвэрийн шийдвэрлэгдсэн байдал, эдийн засгийн үр өгөөж нь хангалттай эсэхийг (салбарын стандарт үзүүлэлтийг хангаж буй эсэх) үнэлнэ.
2.6	Эрсдэлийн түвшин	3 оноо	Төслийн эрсдэлийн үнэлгээний үр дүн болон хариу авах арга хэмжээг хангалттай төлөвлөсөн эсэхийг үнэлнэ.

3.5.1. Үндсэн шалгуур үзүүлэлт 1: “Хууль эрх зүйн орчин”

Тодорхойлолт: Холбогдох хууль тогтоомжоор батлагдсан эрх зүйн үндэслэл болон төрийн зүгээс үзүүлэх дэмжлэг байгаа эсэхийг үнэлнэ.

Дэд шалгуур үзүүлэлт	Оноо	Жин	Жишиг үзүүлэлт	Үнэлэх арга, анхаарах зүйл
2.1.1.Холбогдох	3		3: Төслийн эрх зүйн	Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд

хууль тогтоомж, төсөл хэрэгжүүлэх эрх зүйн үндэслэл		<p>орчин бүрдсэн, төрийн дэмжлэг тодорхойлогдсон ба төсөл хэрэгжүүлэх холбогдох тушаал, шийдвэр гарсан</p> <p>2: Төсөл хэрэгжүүлэх эрх зүйн орчин хэсэгчлэн бүрдсэн. Үлдсэн асуудал нь төсөл эхлэхээс өмнө шийдвэрлэгдэх ба төсөл хэрэгжүүлэх тушаал, шийдвэр гарсан.</p> <p>1: Төсөл хэрэгжүүлэх эрх зүйн үндсэн орчин бүрдсэн боловч төрийн дэмжлэг тодорхойлогдоогүй, эсхүл онцгой зохицуулалт, дэмжлэг байхгүй. Гэхдээ төсөл хэрэгжүүлэх тушаал, шийдвэр гарсан.</p> <p>0: Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдээгүй.</p>	<p>шаардлагатай хууль эрх зүйн орчин бүрдсэн эсэхийг нягтална. Төрийн дэмжлэг гэдэг нь тодорхой хууль, тогтоол, хөтөлбөр, төлөвлөгөөний хүрээнд онцгойлон дэмжлэг авах, эсхүл татвараас чөлөөлөгдөх, татварын бус урамшуулал эдлэх, экспорт импортын хязгаарлалт, урамшуулал, дэмжлэг авах зэрэг төрөөс үзүүлэх арга хэмжээг илэрхийлнэ.</p> <p>Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх хууль тогтоомж, тогтоол, журам, шийдвэр, гэрээ батлагдсан, төрийн дэмжлэг болон онцгой зохицуулалт хийгдэх бол эрх зүйн орчин бүрэн бүрдсэн гэж үзэх ба 3 оноо байна.</p> <p>Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх хууль тогтоомж батлагдаагүй боловч гол чухал хууль тогтоомж батлагдсан, төрийн дэмжлэг ба онцгой зохицуулалт тодорхойлогдсон бол хууль эрх зүйн орчин хэсэгчлэн бүрдсэн гэж үзэх ба 2 оноо байна.</p> <p>Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай гол чухал хууль тогтоомж батлагдсан бөгөөд төрийн дэмжлэг ба онцгой зохицуулалт байхгүй бол 1 оноо байна.</p> <p>Төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай хууль тогтоомж батлагдаагүй, мөрдөгдөөгүй бол 0 оноо байна.</p>
---	--	--	--

3.5.2. Үндсэн шалгуур үзүүлэлт 2: “Дэд бүтцийн хүрэлцээ”

Тодорхойлолт: Дэд бүтцийн нөхцөл байдлын хувьд хэрэгжих боломжтой эсэхийг үнэлнэ.

Дэд шалгуур үзүүлэлт	Оноо		Жин	Жишиг үзүүлэлт	Үнэлэх арга, анхаарах зүйл
2.2.1. Төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай дэд бүтэц	3		1	<p>3: Төслийн дэд бүтцийн хэрэгцээ тодорхойлогдсон, дэд бүтэц хүрэлцээтэй байгаа тул нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагагүй.</p> <p>2: Төслийн дэд бүтцийн хэрэгцээ тодорхойлогдсон, өргөтгөл, сайжруулалт хийх, дэд бүтэц шинээр байгуулахад нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай.</p> <p>1: Төслийн дэд бүтцийн хэрэгцээ тодорхойлогдсон, дэд бүтэц шинээр байгуулахад нэмэлт хөрөнгө оруулалт шаардлагатай.</p> <p>0: Төслийн дэд бүтцийн хэрэгцээ тодорхойлогдоогүй.</p>	<p>Төсөл хэрэгжүүлэхэд шаардлагатай дэд бүтцийн байдлын талаар нягтална. Одоо байгаа дэд бүтцэд тулгуурлан төсөл хэрэгжүүлэх боломжтой бол 3 оноо байна. Одоо байгаа дэд бүтэц хүрэлцээгүй бөгөөд шинэчлэх, сайжруулах шаардлагатай бол 2 оноо байна.</p> <p>Шаардлагатай дэд бүтэц байхгүй, шинээр байгуулах, худалдаж авах шаардлагатай бол 1 оноо байна.</p> <p>Дэд бүтцийн хэрэгцээг тодорхойлоогүй бол 0 оноо байна.</p>

3.5.3. Үндсэн шалгуур үзүүлэлт 3: “Төслийн бэлтгэл хангагдсан эсэх

Тодорхойлолт: Төсөл хэрэгжүүлэх бэлтгэл ямар түвшинд байгааг үнэлнэ. Төсөл боловсруулахтай холбогдуулж хийсэн судалгаа, шинжилгээ, төсөл хэрэгжүүлэх удирдлага,

зохион байгуулалт, газар ашиглалтын байдлын хэрэгжих боломжийг нягтална.

Дэд шалгуур үзүүлэлт	Оноо	Жин	Жишиг үзүүлэлт	Үнэлэх арга, анхаарах зүйл
2.3.1.Төсөлд шаардлагатай судалгаа, шинжилгээ хийгдсэн эсэх	3	1	<p>3: Төслийн техник эдийн засгийн үндэслэл, ач холбогдлыг тодорхойлоход шаардлагатай бүхий л судалгаа, шинжилгээг хийж гүйцэтгэсэн.</p> <p>2: Төслийн техник эдийн засгийн үндэслэл, ач холбогдлыг тодорхойлоход шаардлагатай судалгаа, шинжилгээ хэсэгчилсэн байдлаар хийгдэж, урьдчилсан шатны үзүүлэлт бэлэн болсон.</p> <p>1:Төслийн техник эдийн засгийн үндэслэл, ач холбогдлыг тодорхойлох урьдчилсан шатны үзүүлэлт байгаа боловч шаардлагатай судалгаа, шинжилгээ хийгдээгүй.</p> <p>Төслийн техник эдийн засгийн үндэслэл, ач холбогдлыг тодорхойлох шаардлагатай судалгаа, шинжилгээг хийхээр төлөвлөсөн.</p> <p>0: Судалгаа, шинжилгээ хийгдээгүй, төлөвлөөгүй болно.</p>	<p>Дор дурдсан шаардлагатай судалгаа, шинжилгээ хийгдсэн эсэхийг үнэлнэ.</p> <ul style="list-style-type: none"> • Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулах • ТЭЗУС, ТЭЗҮ • Зураг төсөл • Эдийн засгийн дүн шинжилгээ (ЭЗӨДХ-ийн тооцоо) • Үр ашгийн тооцоо, үзүүлэлтүүдийн тооцоолол • Санхүүгийн дүн шинжилгээ (СДӨХ-ийн тооцоо) • Мөнгөн гүйлгээ, санхүүгийн тайлан боловсруулалт • Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ • Эрсдэлийн үнэлгээ • Салбартай холбоотой бусад судалгаа <p>Дээр дурдсан судалгаа, шинжилгээ бүгд хийгдсэн бол 3 оноо өгнө. Үнэлгээ хийхэд нэн шаардлагатай мэдээлэл байгаа бол, тухайлбал, төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөнөөс гадна ЭЗӨДХ, СӨДХ, БОНБУ, Эрсдэлийн үнэлгээ ба хариу авах арга хэмжээний төлөвлөгөө зэрэг зайлшгүй шаардлагатай судалгаа, шинжилгээнүүд хийгдсэн бол 2 оноо байна.</p> <p>Зарим судалгаа, шинжилгээ хийгдсэн боловч мэдээлэл хангалтгүй бол 1 оноо өгнө. Тухайлбал, төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө болон БОНБУ хийгдсэн боловч ЭЗӨДХ-ийн шинжилгээ хийгдээгүй, зөвхөн эдийн засгийн үр өгөөжийг тооцож гаргасан гэх мэт.</p> <p>Шаардлагатай судалгаа, шинжилгээ хийгдээгүй бол 0 оноо байна.</p>
2.3.2.Төслийн удирдлага, зохион байгуулалт	3	1	<p>3: Удирдлага зохион байгуулалтын үндсэн бүтэц, төсөл хэрэгжүүлэх нэгж нь тодорхой болж батлагдсан, гэрээ хэлэлцээрүүд байгуулагдсан.</p> <p>2: Удирдлага зохион байгуулалтын үндсэн бүтэц батлагдсан, төсөл хэрэгжүүлэх нэгж тодорхойлогдож, гэрээ хэлэлцээрүүд хийгдэж байгаа.</p> <p>1: Төсөл хэрэгжүүлэх нэгж нь тодорхойлогдож, төслийн үйл ажиллагаа эхлэхээс өмнө батлагдаж бэлэн</p>	<p>Төсөл хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын байдлыг үнэлнэ.</p> <p>Төсөл хэрэгжүүлэх нэгж, удирдлага зохион байгуулалтын бүтэц болон холбогдох талуудын гүйцэтгэх ажил үүрэг гэрээ хэлэлцээрт тодорхой тусгагдаж, батлагдсан бол 3 оноо байна.</p> <p>Удирдлага зохион байгуулалтын бүтэц болон гүйцэтгэх ажил үүрэг тодорхой болсон ч гэрээ хэлэлцээр батлагдах түвшинд байгаа бол 2 оноо байна.</p> <p>Удирдлага зохион байгуулалтын бүтэц тодорхой болсон ч гэрээ хэлэлцээр хийгдээгүй бол 1 оноо байна.</p> <p>Удирдлага зохион байгуулалтын бүтэц төслийн төлөвлөгөөнд тусгагдсан</p>

			болно. 0: Төсөл хэрэгжүүлэх нэгж байгуулах талаар төслийн төлөвлөгөөнд тусгана.	боловч талуудын хооронд ямар нэг тохиролцоонд хүрээгүй байгаа бол 0 оноо байна.
2.3.3.БОНБУ, газар чөлөөлөлт хийгдсэн эсэх	3	1	3: БОНБУ хийгдэж, төсөл хэрэгжүүлэх газрын эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгогдсон, ямар нэг маргаангүй, газар чөлөөлөлт хийгдсэн. 2: БОНБУ хийгдэж, төсөл хэрэгжүүлэх газрын эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгогдсон, ямар нэг маргаангүй хэдий ч газар чөлөөлөлт хийгдээгүй. 1: БОНБУ хийгдэж, төсөл хэрэгжүүлэх газрын эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгогдсон ч маргаантай эсхүл орон нутгийн иргэд эсэргүүцдэг, газар чөлөөлөлт хийгдээгүй. 0: БОНБУ хийгдээгүй эсхүл төсөл хэрэгжих газрын зөвшөөрөл олгогдоогүй.	Төсөл хэрэгжүүлэх газрын бэлэн байдлыг үнэлнэ. БОНБУ болон газар чөлөөлөлт хийгдсэн, оршин суугчидтай маргаангүй, газар эзэмших, ашиглах гэрчилгээ олгогдсон, газар дээр шууд үйл ажиллагаа явуулж болохоор нөхцөл бүрдсэн бол 3 оноо. БОНБУ хийгдсэн, оршин суугчидтай ямар нэг маргаангүй, газар эзэмших, ашиглах гэрчилгээ олгогдсон боловч газар чөлөөлөлт хийгдээгүй бол 2 оноо байна. БОНБУ хийгдсэн, газар эзэмших, ашиглах гэрчилгээ олгогдсон боловч оршин суугчидтай маргаантай, газар чөлөөлөлт шууд хийх боломжгүй бол 1 оноо байна. Газар эзэмших, ашиглах гэрчилгээ олгогдоогүй бол 0 оноо байна.

3.5.4. Үндсэн шалгуур үзүүлэлт 4 : “Төлөвлөлт, шийдлийн хувьд хэрэгжих боломжтой эсэх”

Тодорхойлолт: Төслийн бүтээн байгуулалтын болон ашиглалтын үе шатны төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжих боломж, үндэслэлийг үнэлнэ.

Дэд шалгуур үзүүлэлт	Оноо	Жин	Жишиг үзүүлэлт	Үнэлэх арга, анхаарах зүйл
2.4.1.Төслийн зорилго, зорилт, шалгуур үзүүлэлт, үр дүн, жил бүрийн хүрэх түвшин, санхүүжилтийн төлөвлөгөө нь тодорхой, хэмжигдэхүйц байдлаар тодорхойлогдсон эсэх	3	1	3: Бүгдийг нарийвчлан тодорхойлсон, үндэслэлтэй. 2: Бүгдийг ерөнхий байдлаар тодорхойлсон, үндэслэлтэй, 1: Зарим үзүүлэлт, зорилтот түвшин хэт ерөнхий эсхүл хэмжигдэхүйц биш. 0: Хэт ерөнхий, үнэлэхэд төвөгтэй.	Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөнд төслийн зорилт, жил бүрийн зорилтот түвшин нь тодорхой тоон үзүүлэлтээр тусгагдсан, зорилтыг хангахаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа, хүрэх үр дүн, үнэлэх үзүүлэлт нь хэмжигдэхүйц бол 3 оноо байна. Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөнд төслийн зорилт нь тусгагдсан, зорилтыг хангахаар хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үр дүн, үнэлэх үзүүлэлт нь хэмжигдэхүйц боловч жил бүрийн зорилтот түвшин хангалтгүй бол 2 оноо байна. Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөнд зарим зорилт, жил бүрийн зорилтот түвшнийг тусгасан боловч тоон үзүүлэлтээр хэмжигдэхүйц үзүүлэлт цөөн эсхүл үзүүлэлт нь тохиромжгүй бол 1 оноо байна. Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөөнд зорилт, жил бүрийн зорилтот түвшин болон хүрэх үр дүн, үзүүлэлтийг тусгаагүй бол 0 оноо байна.
2.4.2.Төслийн	2	1	3: Бүрэн үндэслэлтэй.	Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны

<p>бүтээн байгуулалт болон ашиглалтын үе шатны "Үйл ажиллагааны төлөвлөгөө" боловсруулагдсан эсэх</p>			<p>2: Зарим талаар үндэслэлтэй 1: Үнэлэхэд төвөгтэй, ойлгомжгүй 0: Төсөл хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулагдаагүй.</p>	<p>төлөвлөгөөнд зорилт, зорилгын дагуу үйл ажиллагаа төлөвлөгдсөн бөгөөд тэр нь хэрэгжих үндэслэлтэй эсэхийг нягтална. Төлөвлөгөө нь бодитой бөгөөд зорилт, зорилгыг хангахын тулд хэрэгжүүлэх үйл ажиллагаа нь бүгд хэрэгжих үндэслэлтэй бол 3 оноо байна. Зарим үйл ажиллагаа нь хэрэгжих үндэслэлгүй бол 2 оноо байна. Үйл ажиллагаа, хүрэх үр дүн, зорилтын уялдаа холбоо тодорхойгүй, үйл ажиллагааг үнэлэх боломжгүй бол 1 оноо байна. Төслийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд үйл ажиллагааны цар хүрээг тодорхойлоогүй бол 0 оноо байна.</p>
<p>2.4.3.Төслийн техник, технологийн шинэ, шинэлэг, инноваци шингэсэн байдал</p>	<p>3</p>	<p>1</p>	<p>3: Шинэ, шинэлэг техник технологийг нэвтрүүлнэ. 2: Дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлнэ. 1: Практикт нийцтэй техник технологийг ашиглана. 0: Тодорхойлоогүй, мэдээлэл байхгүй.</p>	<p>Шинэ, шинэлэг, инноваци бүхий техник технологи гэдэг нь: а.Технологи нь төслийн мөчлөгөөс (бүтээн байгуулалтын болон ашиглалтын хугацаа) урт хугацаанд ашиглагдах, б. Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, ус, эрчим хүч зэрэг нөөцийн ашиглалтыг сайжруулах, хүрээлэн буй орчныг харгалзсан ухаалаг технологи ба шинэлэг шийдэл нэвтрүүлсэн эсхүл одоогийн байгаа түвшнийг нь дээшлүүлэх зүйл, в. Улс дотооддоо хэрэглэж болох, практикт нийцтэй, шинэлэг шийдэл зэрэг бөгөөд эдгээр зүйлүүдтэй таарч байвал 3 оноо байна. Дээрх а-в-д дурдсан бүх зүйл биш боловч заримтай нь таарч байвал 2 оноо байна. Одоогийн техник, технологи бөгөөд иргэдийн хэрэгцээ, шаардлагад нийцэж байвал 1 оноо байна. Техник, технологийн талаар судлаагүй, мэдээлэл хангалтгүй бол 0 оноо байна. Тухайлбал, нийтийн тээврийг цахилгаан тээврийн хэрэгсэл болгох бол 3 оноо, дизель хөдөлгүүртэй бол 1 оноо, дизель хөдөлгүүртэй боловч агаарын бохирдолд бага нөлөө үзүүлдэг цэвэр түлштэй бол 2 оноо байна. Ердийн төсөл бол 1 оноо ба инноваци бүхий технологи ашиглах бол оноо нэмэгдэнэ. *Жич: Үйлдвэрлэлийн төслийн хувьд Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан "Үйлдвэрлэлийн төслийн технологийн түвшнийг үнэлэх</p>

3.5.5. Санхүү эдийн засгийн хувьд хэрэгжих боломжтой эсэх

Тодорхойлолт: Төслийн санхүүжилтийн эх үүсвэр болон эдийн засгийн үр өгөөж хангалттай эсэхийг (салбарын стандартыг хангах эсэх) үнэлнэ.

Үнэлэх арга: Санхүүжилтийн эх үүсвэр бол төслийн хэрэгжилтэд маш чухал зүйл тул оноо нь 3, жин нь 3, нийт 9 оноотой байна. Эдийн засгийн үр өгөөжтэй байдалд хамаарах дэд шалгуур үзүүлэлтийн оноо нь 3, жин нь 1 оноотой байна.

Дэд шалгуур үзүүлэлт	Оноо	Жин	Жишиг үзүүлэлт	Үнэлэх арга, анхаарах зүйл
2.5.1.Төслийн санхүүжилтийн эх үүсвэр амлагдсан эсэх	3	3	3: Бүрэн амлагдаж, холбогдох шийдвэр гарсан. 2: Амлагдсан ба холбогдох шийдвэр хүлээгдэж буй. 1: Шийдвэрлэгдээгүй боловч хэлэлцээрийн шатанд байгаа. 0: Тодорхойгүй.	Төслийн санхүүжилтийн эх үүсвэр шийдвэрлэгдсэн эсэхийг нягтална. Санхүүжилтийн эх үүсвэр амлагдсан гэдэг нь төслийн нийт төсвийг санхүүжүүлэх эх үүсвэр тодорхойлогдон, гэрээ хэлэлцээр батлагдсан байхыг хэлэх бөгөөд энэ тохиолдолд 3 оноо байна. Гэрээ хэлэлцээр үзэглэгдээгүй боловч санхүүжилтийн эх үүсвэрийн талаар тодорхой тохиролцоонд хүрсэн бол 2 оноо. Санхүүжилтийн эх үүсвэрийн талаар хөрөнгө оруулагчтай тохиролцоонд хүрээгүй, хэлэлцээрийн шатанд байгаа бол 1 оноо байна. Санхүүжилтийн эх үүсвэрийн талаар судлаагүй байгаа бол 0 оноо байна.
2.5.2. Төслийн төсөвт өртөг, орлого, зарлага, санхүүгийн тооцоолол бодитой хийгдсэн эсэх	3	1	3 : 80 хувиас дээш итгэх түвшинтэй 2 : 50-80 хувийн итгэх түвшинтэй 1:50 хүртэлх хувийн итгэх түвшинтэй 0: хийгдээгүй, үндэслэлгүй эсхүл мэдээлэлгүй	Төсөвт өртөг, орлого, зарлага, мөнгөн урсгал, санхүүгийн тайлан гм үндэслэлтэй эсэх, санхүүгийн тооцоолол зөв хийгдсэн эсэхийг шалгана. Төслийн төсөвт өртөг, орлого, зарлага, мөнгөн урсгал, санхүүгийн тайлан гэх мэт үндэслэл тодорхой, санхүүгийн тооцоолол харьцангуй бодитой буюу 80 хувийн итгэх түвшинтэй бол 3 оноо. төсөвт өртөг, орлого, зарлагын үндэслэл тодорхойгүй хэсэг байгаа ч, санхүүгийн тооцоолол бодит буюу 50-80 хувийн итгэх түвшинтэй бол 2 оноо. төсөвт өртөг, орлого, зарлагын үндэслэл бусад ижил төрлийн төсөлтэй харьцуулахад ихээхэн зөрүүтэй, 50 хүртэлх итгэх түвшинтэй бол 1 оноо. Санхүүгийн тооцоолол хийгдээгүй эсхүл мэдээлэл байхгүй тохиолдолд 0 оноо.
2.5.3. Төслийн санхүү, эдийн засгийн үр өгөөж,	3	1	3: Төслийн санхүү, эдийн засгийн өгөөжийг илтгэх нийтлэг үзүүлэлт	Төслийн санхүү, эдийн засгийн үр өгөөж нь хөрөнгийн боломжит өртгийг үндсэн үзүүлэлт болгон

хөрөнгө оруулалт хийх нөхцөлийг хангасан эсэх			шаардлагыг хангаж, тодорхой эрсдэл (алдагдалтай ажиллах) даах чадвартай тохиолдолд 2 : Төслийн санхүү болон эдийн засгийн өгөөж, үр ашгийг тодорхойлох үзүүлэлт шаардлага хангаж байгаа ч зарлага орлогоос давсан тохиолдолд үзүүлэлт шаардлага хангахгүй тохиолдолд 1 : Төслийн санхүүгийн болон эдийн засгийн өгөөж, үр ашгийг тодорхойлох үзүүлэлт тооцоолол хийгдээгүй ч мөнгөн урсгал тодорхой тооцоологдсон тохиолдолд 0: Тооцоолол хийгдээгүй, мөнгөн урсгал тодорхой биш, эсхүл мэдээлэл байхгүй	тооцно. Иймд санхүүжилтийн эх үүсвэрээс шалтгаалан үндсэн үзүүлэлт нь өөрчлөгдөх хэдий ч бонд гаргасан тохиолдолд төслийн хэрэгжилтийн үе шаттай зэрэгцэн бондын хүү бодогдох тул, Эх үүсвэрийн жигнэсэн дундаж зардлыг (Weighted Average Cost of Capital, WACC) үзүүлэлтээр авна. Төслийн санхүү болон эдийн засгийн үр өгөөж нь зээлийн хүү WACC нь үндсэн үзүүлэлтээс давж, мэдрэмжийн шинжилгээний дүнд тодорхой эрсдэл (зардал 10% өсөж, орлого 10% буурсан түвшин) даах тохиолдолд 3 оноо өгнө. Төслийн санхүү болон эдийн засгийн үр өгөөж нь зээлийн хүү WACC үндсэн үзүүлэлтээс давж, мэдрэмжийн шинжилгээний дүнд тодорхой эрсдэлд (зардал 10% өсөж, орлого 10% буурсан түвшин) үзүүлэлт буурах тохиолдолд 2 оноо. Төслийн санхүүгийн болон эдийн засгийн өгөөж, үр ашгийг тодорхойлох үзүүлэлт тооцоолол хийгдээгүй ч мөнгөн урсгал тодорхой тооцоологдсон тохиолдолд 1 оноо өгнө.
2.5.4. Төслийн санхүү болон эдийн засгийн үр өгөөжийг илтгэх тусгай үзүүлэлтүүд	3	1	3 : Салбарын дунджаас дээш 2:Дундаж түвшинд 1:Дунджаас доош 0 : Тооцоолол хийгдээгүй эсхүл мэдээлэл байхгүй	Санхүү болон эдийн засгийн үр өгөөжийг тодорхойлох салбарын онцлогоос хамаарсан тусгай үзүүлэлтүүд (нэгжийн өртөг) байвал дурдаж, салбарын дундаж үзүүлэлттэй харьцуулж үнэлнэ. Түүнчлэн санхүүгийн болон эдийн засгийн өгөөж, үр ашгийг тооцоолох боломжгүй, орлогогүй төслийн тухайд дээрх нэгжийн өртгөөр үр ашгийг харьцуулах боломжтой.

3.5.6. Төслийн эрсдэлийн шинжилгээ

Тодорхойлолт: Төслийн хэрэгжилт, ашиглалтын шатанд учирч болзошгүй эрсдэлийг бодолцон, эрсдэлийн түвшин болон магадлалыг тооцоолон, сэргийлэх арга хэмжээ төлөвлөсөн эсэхэд үнэлгээ өгнө.

Үнэлэх арга: Төслийн хэрэгжилтийн болон үйл ажиллагаа явуулах шатны эрсдэлийн хэмжээ, үүсэх магадлалыг тооцоолно. Эрсдэлийн шинжилгээний дүнд эрсдэлийн түвшин болон эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулсан эсэхийг тодруулна. “Хөрөнгө оруулалтын төслийн эрсдэлийн шинжилгээг хийх аргачлал”-д суурилсан үнэлгээний түвшнийг тооцож дараах байдлаар үнэлнэ.

Дэд шалгуур үзүүлэлт	Оноо	Жишиг үзүүлэлт	Үнэлэх аргачлал, анхаарах зүйл
6-4.Эрсдэлийн түвшин	3	3 : Эрсдэл бага буюу эрсдэлийн түвшин 10 хүртэл	Төслийн эрсдэлийн онцлог, авах арга хэмжээний талаар жишээ болгон

	<p>дундаж хувиар үнэлэгдсэн.</p> <p>2 : Эрсдэл дунд буюу эрсдлийн түвшин 10-20 дундаж хувиар үнэлэгдсэн.</p> <p>1 : Эрсдэл өндөр буюу эрсдлийн түвшин 20-оос дээш хувиар үнэлэгдсэн.</p> <p>0:Тодорхойлоогүй тодорхойлоход шаардлагатай мэдээлэл байхгүй</p>	<p>дурдав.</p> <p>Барилга угсралтын ажлын шатан дахь эрсдэлд тухайлбал, газар чөлөөлөлтийн эрсдэл, хүрээлэн буй орчны эрсдэл, хөндлөнгийн этгээдэд худалдагдах эрсдэл, хөрөнгө оруулалтын эрсдэл, хууль эрх зүйн заалтын өөрчлөлт, зураг төслийн алдаа гарах эрсдэл, зураг төслийн зохицуулалтын эрсдэл, Барилгын материалын үнийн өсөлт, тооцоолоогүй эрсдэл (байгалийн гамшиг, хүний хүчин зүйлсээс шалтгаалсан урьд. тооцоолох аргагүй хохирол) зэрэг орно.</p> <p>Ашиглалтын шатанд үүсэх эрсдэл нь удаан хугацаанд засвар үйлчилгээ хийхгүйгээс үүсэх эрсдэл, нийлүүлэлтийн эрсдэл, хөндлөнгийн этгээд хохирол учруулах, алдагдал ашгийн эрсдэл, нийгмийн алдагдал. хөдөлмөрийн гарз хохирол, үнийн хэлбэлзэл зэрэг байна</p> <p>Эрсдэлийн шинжилгээний дүнд эрсдэлийн түвшин бага гэж тодорхойлогдсон, эрсдэлээс сэргийлэх, бууруулах төлөвлөгөө боловсруулагдсан бол 3 оноо.</p> <p>Эрсдэлийн шинжилгээний дүнд эрсдэлийн түвшин дунд гэж тодорхойлогдсон, эрсдэлээс сэргийлэх, бууруулах төлөвлөгөө боловсруулагдсан бол 2 оноо.</p> <p>Эрсдэлийн шинжилгээний дүнд эрсдэлийн түвшин өндөр гэж тодорхойлогдсон, эрсдэлээс сэргийлэх, бууруулах төлөвлөгөө боловсруулагдсан бол 1 оноо.</p>
--	--	--

3.6. Төслийг оноогоор үнэлэх

Дээрх “Ач холбогдол” ба “Хэрэгжих боломж” гэсэн хэмжээст үндсэн шалгуур тус бүрээр үнэлэгдсэн онооны нийлбэрийг тооцно. “Ач холбогдол” ба “Хэрэгжих боломж” хэмжээс тус бүрээр Үнэлэгдсэн онооны нийлбэрийг авбал зохих дээд онооны нийлбэрт харьцуулан авбал зохих онооны хэдэн хувиар үнэлэгдсэнийг тодорхойлно. Авбал зохих онооны хэдэн хувийг авсныг үндэслэн хэмжээс тус бүрийг дараах байдлаар үсгэн үнэлгээгээр үнэлэх ба энэ нь төслийг эрэмбэлэхэд баримтлах үндсэн үзүүлэлт болно.

Ач холбогдол		Хэрэгжих боломж	
Авбал зохих оноонд эзлэх хувь	Үсгэн үнэлгээ	Авбал зохих оноонд эзлэх хувь	Үсгэн үнэлгээ
80-аас дээш	A	80-аас дээш	A
65%-80%	B	65%-80%	B
65%-аас доош	C	65%-аас доош	C

Төсвийн ерөнхийлөн захирагч нь УХОХ-т тусгуулах төслийн саналаа Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлэхдээ тэдгээр төслүүдийн Урьдчилсан болон Иж бүрэн үнэлгээг хийн, аргачлалын Хавсралт 3, Хавсралт 4, Хавсралт 5 дугаар маягтуудын дагуу гаргасан дүгнэлтээ төслийн саналын маягтуудын

хамт хүргүүлнэ. Үүн дээр Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бие даасан үнэлгээг нэмж хийнэ.

Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төслийн тэргүүлэх эрэмбийг тодорхойлох ба "Үндэсний хөгжлийн чиг хандлага" болон "Салбар хоорондын уялдааг хангах" гэсэн цогц хөгжлийн бодлого талаас төслийн онцлогийг харгалзан, Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бие даасан байр сууринаас төслийн үр өгөөжийг үнэлэх зорилгоор энэхүү бие даасан үнэлгээний шалгууруудыг тогтоосон.

Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын бие даасан үнэлгээ нь дээр дурдсанчлан, 1. Үндэсний хөгжилд нөлөөлөх ач холбогдол талаас харах өнцөг, 2. Салбар хоорондын уялдаа талаас төслийн үр өгөөжийг харах гэсэн 2 өнцөгтэй. Ихэвчлэн нэг салбарын төсөл боловсруулдаг ТЭЗ-аас ялгаатай тал нь Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь Улсын хөгжлийн урт, дунд хугацааны бодлого, Бүсчилсэн хөгжлийн бодлогын шалгуур үзүүлэлттэй уялдаа холбоог харахаас гадна хэд хэдэн салбарт нөлөөлөх эсхүл салбар дамнасан төслийг хэрэгжүүлснээр гарах харилцан үр өгөөжийг харгалзан үнэлгээ хийнэ.

Дэд шалгуур үзүүлэлт	Дээд оноо	Жин	Жишиг үзүүлэлт	Үнэлэх арга, анхаарах зүйл
1-5.Төсөл арга хэмжээ нь урт, дунд хугацааны болон бусад бодлогын баримт бичигт туссан зорилтыг хангахад чиглэсэн эсэх	3	2	3: Урт, дунд хугацааны болон бусад бодлогын баримт бичигт туссан тус бүр нэгээс дээш зорилго, зорилтыг зэрэг хангахад чухал нөлөө үзүүлнэ. 2: Урт хугацааны бодлогын баримт бичгээс бусад дунд хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримтад туссан нэгээс дээш зорилго, зорилтыг хангахад чухал нөлөө үзүүлнэ. 1: Дунд хугацааны хөгжлийн бодлогын бичиг баримтын аль нэг зорилго, зорилтыг хангахад чухал нөлөө үзүүлнэ. 0: Ямар бодлогын зорилтыг хангахад чиглэсэн нь тодорхойгүй.	Хөгжлийн бодлогын зорилтыг хангахад нөлөөлөх төсөл, арга хэмжээ болохыг тодорхойлно. *Улсын урт, дунд хугацааны болон бусад бодлогын баримт бичигт туссан зорилтуудыг зэрэг хангахад нөлөөлөх ач холбогдолтой бол 3 оноо өгнө. Ж: Уг төслийг хэрэгжүүлснээр Алсын хараа 2050-д туссан нэг зорилт, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн 2 зорилт, Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 1 зорилтыг зэрэг хангах боломж бүрдэж байвал 3 оноо өгнө. Урт хугацааны бодлогын зорилтот нөлөөлөхгүй хэдий ч Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн аль алинд нь туссан тохиолдолд 2 оноо өгнө. Дунд хугацааны хөгжлийн бодлогын аль нэгэнд туссан бол жишээлбэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн аль нэгэнд туссан бол 1 оноо өгнө.
2-3.Үндэсний хөгжлийн бодлогын уялдаа хангахад ач холбогдолтой эсэх	3	1	3: Үндэсний хөгжлийн бодлогын уялдаа хангахад шууд, хүчтэй нөлөөтэй ба чухал ач холбогдолтой. 2: Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн уялдааг	УХОХ-т тусгагдсан бусад төсөл хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлснээр, харилцан үр өгөөж нэмэгдэх, үндэсний хөгжлийн бодлогын уялдааг хангахад шууд, хүчтэй ач холбогдолтой бол 3 оноо. УХОХ-т тусгагдсан бусад төсөл

			<p>хангахад чухал ач холбогдолтой.</p> <p>1:УХОХ-т тусгагдаагүй бусад төсөл хөтөлбөртэй уялдан, харилцан үр өгөөжийг нэмэгдүүлэх ач холбогдолтой</p> <p>0:Үнэлгээнд хамаарахгүй</p>	<p>хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлснээр Монгол улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн уялдааг хангахад чухал ач холбогдолтой бол 2 оноо.</p> <p>УХОХ-т тусгагдаагүй бусад төсөл хөтөлбөртэй уялдсанаар харилцан үр өгөөж нь нэмэгдэх нь тодорхой бол 1 оноо өгнө.</p>
<p>3-8. Үндэсний хөгжлийн бодлогын хүрээнд тухайн төсөл, арга хэмжээ нь нийгмийн ач холбогдолтой эсэх</p>	3	1	<p>3:Тухайн төсөл арга хэмжээг улсын хөгжлийн бодлоготой уялдуулснаар нийгмийн ач холбогдол нэмэгдэнэ.</p> <p>2:Тухайн төсөл арга хэмжээг салбар хоорондын хөгжлийн бодлоготой уялдуулснаар нийгмийн ач холбогдол нэмэгдэнэ</p> <p>1 : Бүсчилсэн хөгжлийн бодлогын уялдааг хангаснаар нийгмийн ач холбогдол нэмэгдэнэ.</p> <p>0 : Тухайн төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол нь тодорхойгүй, тодорхойлогдоогүй, эсхүл тодорхой нөлөөгүй.</p>	<p>Хөгжлийн цогц бодлогын хүрээнд тухайн төсөл нийгмийн ач холбогдолтой эсэхийг үнэлнэ.</p> <p>Тухайн төсөл арга хэмжээг улсын хөгжлийн бодлоготой уялдуулах замаар нийгмийн ач холбогдол нэмэгдэх нь тодорхойлогдвол 3 оноо өгнө.</p> <p>Тухайн төсөл арга хэмжээ нь тухайн салбарын хөгжлийн хүрээнд нийгмийн ач холбогдолтой бол 2 оноо.</p> <p>Жишээлбэл, Гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийн тухайд сургууль, цэцэрлэг, эмнэлэг, зам, цэвэр бохир ус, ариутгах татуурга, дулааны дэд станцыг нь цогцоор барьснаар амьдрах орчин сайжирч, хүн амын эрүүл мэнд, боловсролын асуудал сайжирна гм.</p> <p>Бүсчилсэн хөгжлийн бодлогын уялдааг хангаснаар нийгмийн ач холбогдол нэмэгдэх бол 1 оноо өгнө.</p> <p>Тухайн төсөл, арга хэмжээний нийгмийн ач холбогдол нь тодорхойгүй, тодорхойлогдоогүй, эсхүл тодорхой нөлөөгүй бол 0 оноо.</p>
<p>4-8. Үндэсний хөгжлийн бодлогын хүрээнд тухайн төсөл, арга хэмжээ нь эдийн засгийн өндөр ач холбогдолтой эсэх</p>	3	1	<p>3:Тухайн төсөл арга хэмжээг улсын хөгжлийн бодлоготой уялдуулснаар эдийн засгийн ач холбогдол нэмэгдэнэ.</p> <p>2:Тухайн төсөл арга хэмжээг салбар хоорондын хөгжлийн бодлоготой уялдуулснаар эдийн засгийн ач холбогдол нэмэгдэнэ.</p> <p>1:Бүсийн болон орон нутгийн хөгжлийн бодлогын уялдааг хангаснаар эдийн засгийн ач холбогдол нэмэгдэнэ. 0 : Тухайн төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж нь тодорхойгүй, тодорхойлогдоогүй, эсхүл тодорхой нөлөөгүй.</p>	<p>Хөгжлийн цогц бодлогын хүрээнд эдийн засаг, хөрөнгө оруулалтын үр өгөөжийг үнэлнэ.</p> <p>Тухайн төсөл арга хэмжээг улсын хөгжлийн бодлоготой уялдуулснаар эдийн засгийн ач холбогдол нэмэгдэх бол 3 оноо.</p> <p>Тухайн төсөл арга хэмжээг салбар хоорондын хөгжлийн бодлоготой уялдуулснаар эдийн засгийн ач холбогдол нэмэгдэх нь тодорхой бол 2 оноо, Бүсийн болон орон нутгийн хөгжлийн бодлогын уялдааг хангаснаар эдийн засгийн ач холбогдол нэмэгдэх бол 1 оноо.</p> <p>Тухайн төсөл, арга хэмжээний эдийн засгийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөж нь</p>

				тодорхойгүй, тодорхойлогдоогүй, эсхүл тодорхой нөлөөгүй бол 0 оноо.
5-3. Үндэсний хөгжлийн бодлогын хүрээнд тухайн төсөл, арга хэмжээ нь хүрээлэн буй орчинд эерэг нөлөөтэй эсэх	3	1	3: Тухайн төсөл арга хэмжээг улсын хөгжлийн бодлоготой уялдуулснаар хүрээлэн буй орчинд эерэг нөлөө үзүүлнэ. 2: Тухайн төсөл арга хэмжээг салбар хоорондын хөгжлийн бодлоготой уялдуулснаар хүрээлэн буй орчинд нөлөөлөх эерэг нөлөөлөл нэмэгдэнэ. 1 : Бүсчилсэн хөгжлийн бодлогын уялдааг хангаснаар хүрээлэн буй орчинд нөлөөлөх эерэг нөлөөлөл нэмэгдэнэ. 0 : Тухайн төсөл, арга хэмжээний хүрээлэн буй орчинд нөлөөлөх эерэг нөлөө тодорхойгүй эсхүл эерэг нөлөөгүй	Тухайн төсөл арга хэмжээг улсын хөгжлийн бодлоготой уялдуулснаар хүрээлэн буй орчинд эерэг нөлөө үзүүлэх бол 3 оноо. Тухайн төсөл арга хэмжээг салбар хоорондын хөгжлийн бодлоготой уялдуулснаар хүрээлэн буй орчинд нөлөөлөх эерэг нөлөөлөл нэмэгдэх бол 2 оноо. Бүсчилсэн хөгжлийн бодлогын уялдааг хангаснаар хүрээлэн буй орчинд нөлөөлөх эерэг нөлөөлөл нэмэгдэх нь тодорхой бол 1 оноо. Тухайн төсөл, арга хэмжээний хүрээлэн буй орчинд нөлөөлөх эерэг нөлөө тодорхойгүй эсхүл эерэг нөлөөгүй
6-4. Тухайн төсөл, арга хэмжээ нь бүс нутгийн хөгжилд өндөр ач холбогдолтой.	3	1	3 : Бүсчилсэн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хүрээнд тэргүүлэх ач холбогдолтой 2: Тухайн төсөл, арга хэмжээ нь бүсчилсэн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлд нийцэж буй 1 : Төсөл хэрэгжих бүс, орон нутгийн дэд бүтцийн хэрэгцээ, шаардлагыг хангаж буй 0: Эрэмбэ нь тодорхойгүй	Бүсчилсэн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн хүрээнд тэргүүлэх ач холбогдолтой бол 3 оноо. Тухайн төсөл, арга хэмжээ нь бүсчилсэн хөгжлийн зорилтот хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлд нийцэж буй бол 2 оноо. Төсөл хэрэгжих бүс, орон нутгийн дэд бүтцийн хэрэгцээ, шаардлагыг хангаж буй бол 1 оноо. Эрэмбэ тодорхойгүй бол 0 оноо.

Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь ТЕЗ-ийн үнэлгээний хуудсыг нягтлахын зэрэгцээ Иж бүрэн үнэлгээг хийн өөрийн бие даасан үнэлгээний дүнтэй хамт төслийн Үнэлэгдсэн онооны нийлбэрийг дээр дурдсанчлан авбал зохих онооны хэдэн хувиар үнэлэгдсэнийг төсөл бүр дээр тодорхойлно. Үнэлэгдсэн онооны нийлбэрийг авбал зохих зохих онооны хэдэн хувийг авсныг үндэслэн хэмжээс тус бүрийг үсгэн үнэлгээгээр үнэлнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. УХОХ-Т ТУСГАХ ТӨСЛИЙГ ЭРЭМБЭЛЭХ, СОНГОХ АРГАЧЛАЛ

Төслийг эрэмбэлэхдээ а.Урьдчилсан үнэлгээний дүгнэлт, б. Төсвийн ерөнхийлөн захирагчийн ирүүлсэн үнэлгээ болон эрэмбэ, Иж бүрэн үнэлгээний дүгнэлтийг харгалзана. Төслийн “Урьдчилсан үнэлгээ”-ний дүгнэлтийн “Нэн тэргүүнд хэрэгжүүлэх төслүүд” гэсэн ангилалд багтсан төслүүдийг Нэгдүгээрт эрэмбэлэх ба энэхүү багцад хамаарах төслүүдийн дарааллыг эрх бүхий албан тушаалтны саналаар тодорхойлно.


Төслийн “Иж бүрэн үнэлгээний дүгнэлт”д үндэслэн төслүүдийг эрэмбэлэхдээ “Ач холбогдол” болон “Хэрэгжих боломж” гэсэн хэмжээс тус бүр дээр авсан үнэлгээний хослолоор төслүүдийн багц үүсгэнэ. УХОХ нь урт хугацааны эдийн засаг, нийгмийн хөгжлийн тулгуур болох төслүүдийг хамрах зорилготой бөгөөд эрэмбийн хувьд хувьд улсын хөгжлийн ач холбогдол талаас харсан эрэмбэ өндөр байна. Багцын эрэмбийг дараах

хүснэгтэд харуулснаар эрэмбэлэх ба тодруулбал, ач холбогдол нь С үнэлгээтэй тохиолдолд, хэрэгжих боломж нь А байсан ч ач холбогдол нь В, хэрэгжих боломж С үнэлгээтэй багцаас доогуур эрэмбэлэгдэнэ. Мөн адил АВ, ВА багцыг харьцуулахад ач холбогдол А үнэлгээтэй АВ багц дээгүүр үнэлэгдэнэ.

Тухайн нэг багц дах төслүүдийг дотор төслийн тухайд ач холбогдол, хэрэгжих боломж шалгуурын нийлбэр онооны дүнгээр эрэмбэлэнэ.

Хүснэгт 4.1 Төслийн үнэлгээг эрэмбэлэх

Ач холбогдол	Хэрэгжих боломж	Багцын эрэмбэ
A	A	1
A	B	2
B	A	3
B	B	4
A	C	5
B	C	6
C	A	7
C	B	8
C	C	9



Зураг 4.1 Төслийн үнэлгээг эрэмбэлэх загвар

Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь дээр дурдсанчлан улсын болон салбар хоорондын хөгжлийн бодлогын нэгдмэл, цогц, харилцан уялдаатай байх зарчимд тулгуурлан төслийн нэгдсэн оноо болон үсгэн үнэлгээ, хэлэлцүүлэг, зөвшилцлийн дүнд нэгдсэн дүгнэлтийг гаргана.

Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын гаргасан “Иж бүрэн үнэлгээний дүгнэлт”-ийн үнэлгээний оноо, төслийн эрэмбэ ТЭЗ-ийн ирүүлсэн үнэлгээ ба эрэмбээс зарчмын томоохон зөрүүтэй /50-с дээш хувийн/ гарсан бол эрх бүхий албан тушаалтнуудыг оролцуулсан зөвшилцөх уулзалт хийн, уулзалтын үр дүнгээр шийдвэрлэнэ. Иж бүрэн үнэлгээний үсгэн дүн хоёр хэмжээс тус бүр дээр С үнэлгээтэй буюу 9-р багцын эрэмбээс бусад төслүүдийг УХОХ-т тусгана. Хэрэв эдгээр төслүүд нь Төсвийн тухай хууль,

Өрийн удирдлагын тухай хууль, Төсвийн хүрээний мэдэгдэл болон гадаад өрийн зохистой түвшинтэй нийцээгүй бол нийцтэл нь багц 8, багц 7 гэх мэтээр урагшлуулан хасна.

Урьдчилан үнэлгээний дүгнэлтээр хасагдсан болон Иж бүрэн үнэлгээний үр дүнгээр 9-р багцад хамааран хасагдаж байгаа төслүүдийг УХОХ-т тусгахгүй хассан тухай мэдэгдлийг холбогдох тайлбар болон цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх саналын хамт холбогдох Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь төслийн эрэмбэ тогтоон, сонголт хийсэн эцсийн дүгнэлтийг “Улсын Хөрөнгө Оруулалтын Хөтөлбөрт тусгах төслийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох, хэрэгжилтэд хяналт тавих аргачлал”-ын Хавсралт 10-д үзүүлсэн маягтын дагуу гарган, эрэмбэ тогтоон, сонголт хийсэн албан хаагчид болон Эрх бүхий албан тушаалтан баталгаажуулна.

Баталгаажсан дүгнэлтийг Төсвийн ерөнхийлөн захирагчид руу албан бичгээр илгээн саналыг авах ба хэрэв ТЕЗ өөр саналтай байвал өөр саналтай байгаа ТЕЗ болон эрх бүхий албан тушаалтнуудыг оролцуулсан зөвшилцөх уулзалт хийн, уулзалтын үр дүнгээр шийдвэрлэнэ.

Сонгогдоогүй төслүүдийн тухайд УХОХ-т тусгагдаагүй учир шалтгаан, үндэслэлийн тайлбарлан ТЕЗ-д эргэн мэдээлнэ. Төслийн ач холбогдол, хэрэгжих боломжийн хувьд засаж сайжруулах боломжтой, санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүй төслийн тухайд дараагийн УХОХ-т санал тавихад анхаарах, сайжруулах тал дээр зөвлөмж өгнө.

ТАВДУГААР БҮЛЭГ. УХОХ-Т ТУССАН ТӨСЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ХЯНАХ

5.1 УХОХ-т тусгагдсан төслийн хэрэгжилтийг хянах

Өмнө дурдсанчлан төслийн хяналт шинжилгээний гол зорилго нь хэрэгжиж буй төслүүдийг дараагийн УХОХ-т тусгах эсэхийг шийдвэрлэх юм. Хяналт-шинжилгээ нь төслийн үйл ажиллагааны явцыг хянах үйл ажиллагааны хяналт-шинжилгээ болон санхүүжилтийн гүйцэтгэлийн явц болон нийт өртгийг хянах санхүүгийн хяналт- шинжилгээ гэсэн 2 талтай. Аль аль нь төслийн хэрэгжүүлэх үйл ажиллагааг (үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэл) тухайн жилийн төлөвлөлтийн дагуу хэрэгжиж буй эсэхийг хянах явцын хяналт-шинжилгээг гол цөм болгон нэгтгэн, төслийн хүрэх үр дүн болон төслийн зорилгод хүрсэн эсэхийг хүрэх үр дүнгийн хяналт-шинжилгээ, дотоод гадаад эрсдэлийг хянах эрсдэлийн хяналт-шинжилгээний өгөгдлийг агуулсан байна. Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын шилжин ирэх төслийн хяналт-шинжилгээний нийт үе шатыг дараах зурагт харуулав.



Зураг 5.1 Хяналт-шинжилгээний явц

1) **Хяналт-шинжилгээний тайлан гаргуулах.** УХОХ-ийг боловсруулах, тодотгох чиг үүрэг бүхий бүтцийн хяналт шинжилгээ хариуцсан нэгж тогтсон маягтын дагуу ТЕЗ-аас төсөл тус бүрийн үйл ажиллагаа болон санхүүгийн явцын тайланг гаргуулж авна. Жил бүрийн 12 сард Төсвийн ерөнхийлөн захирагчид УХОХ-т тусгагдсан төслийн явцын тайлан гаргуулах удирдамж хүргүүлж, 2 дугаар сарын 15-ны дотор хүлээн авна. УХОХ-ийг боловсруулах, тодотгох чиг үүрэг бүхий бүтцийн хяналт шинжилгээ хариуцсан нэгж нь хүлээж авсан төслүүдийн явцын тайланд үндэслэн нэмэлт мэдээлэл тодруулга авна. Түүнчлэн тухайн жилийн төсөв болон Санхүү төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын өрийн удирдлагын мэдээлэл зэрэг санхүү төсвийн баримт нотолгоонд

тулгуурлан төслийн явцыг нягтална.

2) Нэгтгэл буюу УХОХ-ийн тодотгол хийх.

Үндэсний хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага ТЕЗ-аас явцын хяналт шинжилгээний тайланг нэгтгэн дүгнэж "Монгол улсын УХОХ-ийн жилийн эцсийн хэрэгжилтийн тайлан"-г гаргана. Энэ үед УХОХ-т тусгагдсан төслийг "хэрэгжиж дууссан", "хэвийн буюу цаашид хэрэгжих боломжтой", "эргэлзээтэй буюу дахин үнэлэх" гэсэн 3 дүгнэлт гаргана. "Хэрэгжиж дууссан", "цаашид хэрэгжих боломжтой" төслүүд УХОХ-ийн тодотголд тусгагдан (дууссан төслүүд гүйцэтгэлийг харуулах байдлаар дууссан тэмдэглэгээтэйгээр), "эргэлзээтэй буюу дахин үнэлэх" төслийн хувьд дахин авч хэлэлцэнэ. Цаашид хэрэгжүүлэх боломжгүй гэж үзсэн захиргааны шийдвэр гарсан тохиолдолд УХОХ-өөс хасагдана. "Эргэлзээтэй буюу дахин үнэлэх" төслийн тухайд төлөвлөлийн шатанд тооцоолсон төсөвт өртөг эрс нэмэгдсэн буюу үйл ажиллагааны цар хүрээ нэмэгдсэн тохиолдолд тухайн төслийн нийгэм эдийн засаг, хүрээлэн буй орчинд нөлөөлөх нөлөө, зардал үр ашгийн тооцоог дахин шинээр хийлгэж хэрэгжүүлэх боломж, ач холбогдлыг дахин үнэлэх шаардлагатай.